



## ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Байгууллагын нэр: **АШУҮИС-ийн Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль**

Хөтөлбөрийн нэр: **Уламжлалт Анагаахын Засал**

Индекс: **D091704**

Шинжээчийн баг:

Ахлагч: **Г.Чойжамц**

Гишүүд: **Б.Наранцэцэг**

**Л.Наранзаяа**

**Л.Наранцэцэг**

2023 он

## **Агуулга**

### **Товчилсон үгийн тайлбар**

#### **I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт**

#### **II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга**

#### **III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

#### **IV. Уулзалтад оролцогчдын нэрс**

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

#### **V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**

#### **ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр**

#### **ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

## Товчилсон үгийн тайлбар

### I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн /Монгол, Англи/ нэр	АШУҮИС-ийн Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль International School of Mongolian Medicine of National University Medical Sciences	
Сургалтын хөтөлбөрийн /Монгол, Англи/ нэр	Уламжлалт Анагаахын Засал Traditional Medical Therapy	
Индекс	D091704 Бакалавр	
Шинжээчид	<p>1. Г. Чойжамц Оточ Манрамба Их Сургуулийн Дэд захирал, Доктор, Профессор</p> <p>2. Б.Наранцэцэг Шинэ Анагаах Ухааны Их Сургуулийн багш, Дэд доктор</p> <p>3. Л.Наранзаяа “Ач” Анагаах Ухааны Их Сургуулийн харьяа Уламжлалт анагаах ухааны салбар сургуулийн Онолын тэнхимийн эрхлэгч, АУ-ы Доктор</p> <p>4. Л.Оюунцэцэг МУИС-ийн Бизнесийн Сургуулийн НББ-ийн тэнхимийн эрхлэгч, Доктор, Дэд профессор</p>	
БМИҮЗ-ийн ажлын албаны мэргэжилтэн	Магадлан итгэмжлэл хариуцсан шинжээч Б.Оюунцэцэг	
Төлөвлөгөө	2023.01.06	Мэргэжилтэн шинжээчдэд ӨҮТ-г хүлээлгэн өгөх
	2023.01.11	Шинжээчийн урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд өгөх
	2023.01.16	Сургуулийн бэлэн байдлыг нягтлах
	2023.01.17-18	Шинжээчид сургууль дээр ажиллах
	2023.01.27	Шинжээчийн баг зохицуулагчид шинжээчийн тайланг илгээх
	2023.01.30	Магадлан итгэмжлэлд орж буй сургуульд шинжээчийн тайланг илгээх
	2023.02.01	Сургууль шинжээчийн тайлантай танилцаж хариу өгч, шинжээчийн тайлан эцсийн байдлаар бэлэн болох
		Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр гарах
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2016 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 001 дугаар тогтоолоор батлагдсан “Шалгуур, шаардлага шинэчлэн батлах тухай” тогтоолын Хоёрдугаар хавсралтаар батлагдсан шалгуур шаардлагын дагуу ажиллав.	

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

1. 2016 оноос эхлэн хэрэгжүүлж байгаа шинэ хөтөлбөр: АШУҮИС-ийн Захирлын 2016 оны 11 сарын 07-ны Е091702 индекстэй “Уламжлалт Анагаахын Засал хөтөлбөр батлагдсан”, БСШУС-ын 2017 оны 6 сарын 27-ны А/52 дугаар тушаалаар Е091702 “Уламжлалт засал” индекс давтан шинэчлэгдэж, 2022 оны 5 сарын 9-ний А/180 дугаар тушаалаар Е091704 “Уламжлалт Анагаахын Засал” индекс одоогийнхоор эцэслэн батлагдсан.
2. АШУҮИС, Япон улсын Токио Ариаке Их Сургуультай хамтран боловсруулж, гадаад орны их сургуультай хамтран хэрэгжүүлж анх удаа их сургуулиар бэлтгэгдсэн үндэсний дээд боловсролтой, уламжлалт анагаахын засал мэргэжилтэн бэлтгэж байгаа, 3 удаа төгсөлт хийсэн.
3. Төгсөгчидийн ажил эрхлэлтийн хувь, мэргэжилтний хэрэгцээ өндөр.

## III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

### Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

#### 1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

#### Илрэл нотолгоо:

1. Дээд боловсролын тухай хууль
2. Монгол улсын Эрүүл мэндийн тухай хууль
3. Монгол улсын стандарт MNS: 5323-128:2012
4. Уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх төрийн бодлого (2015-2025)
5. АШУҮИС-ийг хөгжүүлэх бизнес төлөвлөгөө (2014-2024)
6. “Монгол анагаах ухаан”-ы хөгжлийн бодлого (2015-2025)
7. Боловсролын чанарын шинэчлэлийн бодлого (2012-2016)
8. АШУҮИС-ийн стратеги төлөвлөгөө

#### Онцлог зүйл:

1. “Японы Жүдо бариа заслын холбоо ба ЖАЙКА олон улсын байгууллагатай хамтарсан “Өвсний үндэс” хөтөлбөрийн 10 сая иен санхүүжилттэй төслийн “Уламжлалт Анагаахын Засал” мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийг АШУҮИС-ийн Монгол анагаах ухааны олон улсын сургууль дээр хэрэгжүүлсэн.
2. Уламжлалт анагаахын засал хөтөлбөрийг Япон улсын Токио Ариаке Их Сургуультай хамтран боловсруулж, гадаад орны их сургуультай хамтран хэрэгжүүлж байгаа.
3. Хөтөлбөрийг боловсруулахдаа холбогдох хууль эрхзүйн дотоодын 7, гадаадын 4 баримт бичиг ашигласны сацуу Японы хэд хэдэн ижил төстэй хөтөлбөртэй харьцуулан судлаж дүгнэлт хийсэн бөгөөд өөрийн орны онцлог, төрөөс боловсролын ба УАУ-ы талаар баримтлаж буй бодлогод нийцсэн агуулгатай болгосон онцлогтой.

4. Төгсөгчдийн мэргэжлийн эрх хамгаалах шалгалтын амжилтыг хөндлөнгийн үнэлгээ хэмээн үзэж энд харуулвал 2020 онд 12 төгсөгч 100%, 2021 онд 14 төгсөгч 100%, 2022 онд 20 төгсөгч 100% шалгагдсан баримт байна.
5. Хөтөлбөрийн ерөнхий ба дэд хороо байгуулагдсан үйл ажиллагаа тогтмолжин үр дүнтэй ажиллаж байна.
6. Тус хөтөлбөрөөр төгсөгч мэргэжилтний хэрэгцээ, ажлын байрны судалгаа хангалттай хийгдсэн.
  - a. Монголын Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа (MNS 5700:2020) стандартад 8-10 оронд уламжлалт засалч 1, уламжлалт бариа заслын сувилагч 1 байхаар тусгагдсан, 2021 оны байдлаар улсын хэмжээнд нийт 4952 эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа ба 10000 хүн тутамд 107,6 ор ногдож байна. Энэ тоон үзүүлэлтэд үндэслэн тооцвол улсын хэмжээнд уламжлалт анагаах ухааны засалч 3531 шаардлагатай.
  - b. Эрүүл мэндийн хөгжилийн төвөөс гаргасан эрүүл мэндийн байгууллагын ажиллагсдын тооны динамик өсөлтийн судалгаа (2016-2021он)-гаар уламжлалт анагаах ухааны салбарт 2016 онд 780, 2021 онд хүртэл 1142 болж нэмэгдсэн.
  - c. Одоогийн байдлаар тус сургууль тэнхимтэй хамтран ажиллаж байгаа спортын байгууллагуудын захиалгад Жүдо бариа засалч суурьтай Уламжлалт анагаахын засалч мэргэжилтний хэрэгцээг тооцож үзвэл Хөл бөмбөгийн 50, Үндэсний бөхийн 50 гэх мэт наанадаж 300 шахам мэргэжилтний хэрэгцээ шаардлага гарч байна.
  - d. Хөтөлбөр хамтран хэрэгжүүлж байгаа Япон улсад 2021 оны байдлаар Жүдо бариа заслын 50364 эмнэлэг, 2019 оны байдлаар 73017 мэргэжилтэн ажиллаж байгаа нь цаашид Монголд ийм эмнэлэг, мэргэжилтний хэрэгцээ өсөх ирээдүйтэй гэж үзэж болохоор ажээ.
7. 2016 онд нээгдсэн уг хөтөлбөрөөр энэ хугацаанд 3 удаа төгсөлт хийж 52 мэргэжилтэн төгссөн. Төгсөгчдийн ажил эрхлэлт: 100%, төгсөгчдөөс Спорт, урлагийн салбарт 23% (тэдгээрийн Хөл бөмбөгийн 41%, Волейболын 13%, Балетийн 13% ,Туяалзуур сэлмийн 9% , Үндэсний ба Жүдо бөх, Хүндийн өргөлтийн шигшээгийн багийн засалчаар тус бүр 6%) ба улсын ба хувийн хэвшлийн эмнэлэгт 67% ажилладаг.
8. Карьер өсөлт: Төгсөлтийн дараах сургалтад хамрагдаж байгаа 10,2%, АШУҮИС-д суралцаж байгаа 7, Япон улсад мэргэжлээрээ магистрантурт суралцаж байгаа 3 төгсөгч тус тус байна.

### **Дүгнэлт:**

1. "Уламжлалт Анагаахын Засал" индекс E091704 хөтөлбөрийн оролцогч талууд Монголын АШУҮИС ба Япон улсын Токио Ариаке Их Сургууль хамтран боловсруулж, 2016 оноос хамтран амжилттай хэрэгжүүлж байгаа, 3 удаа төгсөлт хийсэн.
2. Сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, Монгол улсын эрүүл мэнд, спортын салбарт шинэ технологи нутагшуулж, Япон ба Монголын уламжлал, дээр суурилсан шинэ мэргэжилтэн бэлдэж байгаа бөгөөд эрэлт өндөр мэргэжилтэн бэлдэж байгаа.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж тогтмол сайжруулалт хийж байгаа.

**Үнэлгээ:**

**БҮРЭН ХАНГАСАН**

**Зөвлөмж:**

1. Хөтөлбөрийн оролцогч талуудын санал хүсэлт эрэлт хэрэгцээг тогтмол хугацаанд судлах хамтын үйл ажиллагааг тогтмолжуулж тэдний санал, хүсэлтийг Хөтөлбөрийн зорилго, зорилтод хэрхэн тусгаж хөгжүүлэлт хийж байгаа талаар эргэж мэдээлж байх. УАЗ-ийн оношийн ангилал, эмнэлзүйн удирдамж боловсруулах, хэрэглэх талаар хөтөлбөрийн баг санаачлагатай ажиллах.

## **1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

1. АШУҮИС–ийн захирлын эрхэм зорилго 2021 оны 4-р сарын 26-ны 06 тоот тогтоол
2. МАУОУ-ын их сургуулийн эрхэм зорилгыг АШУҮИС-ийн захирлын зөвлөлийн 2020 оны 5-р сарын 22-ны өдрийн хурлаар баталсан тэмдэглэл
3. “УАЗ”-ийн хөтөлбөрийн зорилгыг АШУҮИС-ийн Монгол Анагаах Ухааны Институтын багш нарын 2015 оны 9 сарын 21-ний хурлаар баталсан тэмдэглэл

**Оролцогч оюутан, багш, төгсөгчид, ажил олгогч талуудын оролцоо:**

**а. Ажил олгогчдоос авсан судалгааны үр дүн**

1. “УАЗ” ажилтны ажлын гүйцэтгэлийн үр чадварын үнэлгээний үр дүн: багаар ажиллах чадвар- сэтгэл ханамжтай, мэргэжлийн үр чадвар- сэтгэл маш ханамжтай, бие даан ажиллах чадвар- сэтгэл ханамжтай.
2. Эзэмшсэн байх шаардлагатай үр чадвар: мэргэжлийн үр чадвар (91.7%), хандлага (83.3%), багаар ажиллах чадвар (75%) харилцааны үр чадвар (66.7%).
3. “УАЗ” хөтөлбөр ажил олгогчдын хэрэгцээ шаардлагад нийцдэг эсэх гэсэн асуумжийн хариу: 58.3% маш сайн, 33.3% сайн, 8.3% дунд түвшинд гэж үзсэн.
4. Хамтарч ажиллах боломжтой эсэх: Оюутан дадлагажуулах хүсэлтэй 91.7%, цагийн ажлын байраар хангах саналтай 33.3% байнгын ажлын байраар хангах боломжтой 33.3%.

**б. Төгсөгчдөөс авсан судалгаа**

1. 2021 онд авсан асуумж судалгаагаар төгсөгчдөөс цаашид үргэлжлүүлэн сурах хүсэлтэй 61.5%, ажиллах хүсэлтэй 30.8%,

суралцах хүсэлтэй төгсөгчдөөс Токио Ариаке их сургуульд магистрын хөтөлбөрт суралцахыг хүсэгч 41.7%, Монголд магистрын хөтөлбөрөөр суралцах хүсэлтэй 8.3%, япон хэл гүнзгийрүүлэн суралцаж мэргэжлээ дээшлүүлэх шаардлагатай гэж үздэг 8,3%.

2. 2022 оны төгсөгчдийн судалгаагаар цаашид мэргэжлээрээ ажиллах төлөвлөгөөтэй 95.8% тэдгээрийн дотроос спортын салбарт 60%, эмнэлэгт 28%.
3. 1-р дамжаанаас эхлэн мэргэжлийн хичээл ордог нь давуу тал гэж үзсэн бөгөөд, цаашид Токио Ариаке их сургуулийг сонгож буй 80%, япон багш нар ирж хичээл зааж байгаа нь давуу тал гэж үзсэн 76%, япон улсад эмнэлзүйн дадлага хийдэг, оюутан солилцоог давуу тал хэмээн үздэг 64%.
4. ТДС, мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдах хүсэлтэй эсэх: 96% тийм, 4% эргэлзээтэй.
5. Хичээлийн хуваарь онол практикийн оновчтой хослолоор явагддаг эсэх: хангалттай 52%, маш сайн ба дунд зэрэг 24%.
6. Хөтөлбөрийн агуулгыг үнэлсэн судалгааны үр дүнгээс үзвэл хичээл хоорондын агуулгын уялдаа холбоо хангалттай 52%, маш сайн 12%, дунд зэрэг 28%, хариулаагүй 8%.

#### **Онцлог зүйл:**

1. Оролцогч талуудтай хамтран ажиллах санал хүсэлтийг судлах сургалтыг улам боловсронгуй болгох асуудалд анхаарах тогтолцоо бүрдүүлсэн.

#### **Анхаарах асуудал:/ Зөвлөмжид үндэслэн бичих/**

1. Мэргэжил сурталчлах идэвхтэй үйл ажиллагаа тасралтгүй явуулах.

#### **Дүгнэлт: /Үнэлгээ өгөх үндэслэл бичих/**

1. Энэхүү хөтөлбөр нь тус сургуулийн эрхэм зорилго, зорилтод нийцсэн Монгол улсын эрүүл мэнд, спорт, урлагийн салбарт эрэлттэй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтэн бэлтгэн, 3 удаа төгсөлтөөр нийт 52 мэргэжилтэн төгсгөсөн байна. Төгсөгчид, ажил олгогчдын хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж байна.
2. Үйлчлүүлэгчид, олон нийтэд хөтөлбөрийн зорилгыг сурталчлах талаар дараах үйл ажиллагааг зохион байгуулсан байна. Үүнд:
  - a. БСШУСЯ-наас зохион байгуулсан сургууль сурталчлах өдөрлөгт 2017 онд оролцож анхны маркетинг сурталчилгаа хийсэн.
  - b. 2017 оны 3-р сард АШУҮИС дээр зохиогдсон мэргэжил сурталчлах өдөрлөгт оролцсон.
  - c. Спортын салбарынханд мэргэжлээ сурталчлах зөвлөгөөг нийт 8 удаа зохион байгуулж 120 тамирчдад анхны тусламж Жүдо бариа заслын ба спортын гэмтлийн үзлэг үйлчилгээ, үзүүлж, зөвлөгөө өгсөн.
  - d. 2017 онд МАУ-ы Клиникээр үйлчлүүлэгчидэд нийт 10 удаа хөлний гажигийн талаар зөвлөгөө өгч мөн 180-р цэцэрлэг дээр 96 хүүхдэд үзлэг эмчилгээ хийсэн.
  - e. Нийслэлийн Ерөнхий боловсролын 7 сургууль төгсөгч 300 гаруй сурагчдад “Уламжлалт Анагаахын Засал” мэргэжил сурталчлах өдөрлөг зохион байгуулсан.

- f. АШУҮИС-ийн Монгол анагаах ухааны олон улсын сургуулийн Веб сайтад мэргэжил сурлалчлах 13 контент байрлуулсаныг нийт хандалт 4161008, эерэг хандалт 1251-ийг авсан байна.

**Үнэлгээ:**

**БҮРЭН ХАНГАСАН**

**Зөвлөмж**

1. Төгсөгчдийн ажиллах байгууллагад зориулсан ажлын байрны тодорхойлолт гаргаж баталгаажуулах, цалингийн сүлжээнд ялгавартай зэрэглэл тогтоолгох боломжийг судалж, зохих шатны байгууллагад уламжлах.

### **1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн аргагүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

1. БСШУ-ны Сайдын 2017оны 6-р сарын 27-ны А/52 болон 2022 оны 5-р сарын 9-ний А/180-р дугаар тушаал
2. Хөтөлбөр хамтран хэрэгжүүлэгч талууд МАУОУС ба Япон улсын Токио Ариаке их сургууль хоорондын хамтын ажиллагааны хүрээнд хөтөлбөрийн төлөвлөлт
3. 2021 оны 10 сарын 27-ны өдөр Ханада академи, Токио Ариакэ эрүүл мэнд анагаах ухааны сургуулийн жүдо бариа заслын тэнхимийн эрхлэгч Нобору Хашимото “УАЗ “мэргэжлийн хөтөлбөрт үнэлгээ хийсэн.
4. Уламжлалт бариа заслын тэнхимийн 2022 оны 10 сарын 21-ний өдрийн хурлаар Уламжлалт анагаахын засал мэргэжлийн хичээлийн танилцуулга хэлэлцүүлгийн бэлтгэл МАУОУС–ийн сургалтын ахиц дэвшлийг нэмэгдүүлэх, хичээл хоорондын уялдаа холбоог сайжруулах ажлын хүрээнд гэмтэл судлал, ортопед, жүдо бариа заслын эмнэлзүйн хичээлийн мэргэжлийн хичээлийн хөтөлбөрийн хэлэлцүүлгийн бэлтгэл, хэрэгжилтэд өөрийн үнэлгээ хийж Хөтөлбөрийн хороогоор хэлэлцэн зарим шинэчлэлт сайжруулалт хийсэн.
5. БСШУ-ы Сайдын 2014 оны 4-р сарын 28-ны өдрийн А/174 тушаал

**Онцлог зүйл:**

1. Уламжлалт бариа заслын тэнхимийн 2022 оны 9 сарын 5-ны өдрийн хурлаар хичээлийн сурах бичгийн хүртээмжийн талаар хэлэлцэж, шинээр гаргах УАЗ-ийн үндсэн анхны сурах бичиг зөвшөөрөгдсөн.
2. Уламжлалт бариа заслын тэнхимийн 2020 оны 10 сарын 18-ны өдрийн хурлаар 2020-2022 оны төгсөгчдийн санал асуулгын үр дүнг хэлэлцэж сайжруулалт хийгдсэн.
3. Жүдо бариа заслын эмнэлзүйн дадлагын баазыг сайжруулахын тулд Монголын хөл бөмбөгийн холбоо, Монголын жүдо бөхийн холбоо, Монголын жүдогийн академи зэрэг байгууллагатай хамтран ажиллах санамж бичиг (2022 оны 22/09 тоот) баталсан.



## **Дүгнэлт: /Үнэлгээ өгөх үндэслэл/**

1. Хөтөлбөр хамтран хэрэгжүүлэгч талууд МАУОУС ба Япон улсын Токио Ариаке их сургууль хоорондын хамтын ажиллагааны хүрээнд хөтөлбөрийн төлөвлөлт, агуулгын боловсруулалт сайн хийгдсэн.
2. Оюутны эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагад нэг талаас МУА-ын бариа засал нөгөө талаас Японы жүдо бариа засал тус бүрийн онол, аргазүйг хослон суралцах бөгөөд эмчлүүлэгчдэд хосолсон үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн бэлтгэж гаргахаар сургалтын төлөвлөгөө ба хөтөлбөрийг боловсруулжээ.

## **Үнэлгээ:**

## **БҮРЭН ХАНГАСАН**

## **Зөвлөмж:**

1. УАЗ-ийн оношийн ангилал, эмнэлзүйн удирдамж боловсруулах, хэрэглэх талаар хөтөлбөрийн баг санаачлагатай ажиллах.
2. Төгсөлтийн дараах сургалтад уг хөтөлбөрөөр төгсөгчид “УАЗ” мэргэжилтнийг хамруулах тогтолцоог хөгжүүлэх боломжийг судлаж зохих шатны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

## **Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа**

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, аргазүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

### **2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл**

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

1. АШУҮИС-ийн “Уламжлалт анагаахын засал” хөтөлбөрийн бакалаврын сургалтын хөтөлбөрүүд
3. АШУҮИС-ийн Төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам А/19 тушаал
4. БШУ-ы сайдын 2014 оны 4 сарын 28-ны өдрийн А/174 тоот тушаалаар батлагдсан “Нийтлэг шаардлага батлах тухай”
5. АШУҮИС-ийн “Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам” 2021 оны 12 сарын 28-ны өдрийн А/19 тушаал
6. АШУҮИС-ийн захирлын 2016.11.07-ны А/36 тоот тушаал
7. БСШУ-ны Сайдын 2017оны 6-р сарын 27-ны А/52 болон 2022 оны 5-р сарын 9-ний А/180 дугаар тушаал
8. Хөтөлбөр хамтран хэрэгжүүлэгч талууд МАУОУС ба Япон улсын Токио Ариаке их сургууль хоорондын хамтын ажиллагааны хүрээнд хөтөлбөрийн төлөвлөлт

9. 2021 оны 10 сарын 27-ны өдөр Ханада академи, Токио Ариаке эрүүл мэнд анагаах ухааны сургуулийн жүдо бариа заслын тэнхимийн эрхлэгч Ноборү Хашимото “УАЗ” мэргэжлийн хөтөлбөрт үнэлгээ.
10. Уламжлалт бариа заслын тэнхимийн 2022 оны 10 сарын 21-ний өдрийн хурлаар “УАЗ” мэргэжлийн хичээлийн танилцуулга хэлэлцүүлгийн бэлтгэл МАУОУС–ийн сургалтын ахиц дэвшлийг нэмэгдүүлэх, хичээл хоорондын уялдаа холбоог сайжруулах ажлын хүрээнд гэмтэл судлал, ортопед, жүдо бариа заслын эмнэлзүйн хичээлийн мэргэжлийн хичээлийн хөтөлбөрийн хэлэлцүүлгийн бэлтгэл, хэрэгжилтэд өөрийн үнэлгээ хийж Хөтөлбөрийн хороогоор хэлэлцэн зарим шинэчлэлт сайжруулалт хийсэн тэмдэгдэл

### **Онцлог зүйл:**

1. Оюутнууд Япон улсад эмнэлзүйн дадлага хийдэг. Япон улсын талаас дадлагын хугацаанд байрлах байр, бусад хэрэглээг хангадаг.

2. Япон улсын Токио Ариаке Их Сургуулийн 8 багш хичээлийн жилд 2 удаа хүрэлцэн ирж Жүдо бариа заслын мэргэжлийн хичээл заадаг. Эдгээр багш нар Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургуульд давхардсан тоогоор нийт 31 удаа ирж Жүдо бариа заслын давхардсан тоогоор нийт 27 хичээл заасан байна.

3. Оюутан солилцооны хүрээнд 2016-2019 онд Токио Ариаке Их Сургуулиас Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль руу 4 удаа нийт 45 оюутан, МАУОУС-иас ТАИС руу 3 удаа 22 оюутан богино, дунд хугацааны оюутан солилцоо, эмнэлзүйн дадлагын хөтөлбөрт хамрагдсан.

4. 2020 оны хамгийн анхны төгсөлтөөс хоёр оюутан, 2021 оны төгсөлтөөс 1 оюутан Япон улсад суралцах 100%-ийн магистрын тэтгэлэг авсан. 3 төгсөгчийн хоёр нь 2023.03 сард Токио Ариаке Их Сургуульд Жүдо бариа заслын магистрын зэргээ хамгаалахаар суралцаж байна.

### **Анхаарах асуудал: /Сул тал/**

1. “УАЗ” мэргэжлээр цаашид сурах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор гадаад хэлний хичээлийн багц цагийг нэмэгдүүлэхэд анхаарах.
2. “УАЗ”-аар суралцаж буй оюутнууд болон төгсөгч нартай уулзах үед динамик анатоми, дүрс оношилгоо зэрэг хичээлүүдийн цагийг нэмэх боломжит нөхцлийг судалж, шийдвэрлэж өгөөч гэсэн саналууд ихээхэн гарсан учир хөтөлбөр хэрэгжүүлэгч баг энэхүү асуудал дээр анхаарах.

### **Дүгнэлт:**

Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль нь хөтөлбөрийн агуулгыг өөрчлөх боломжтой уян хатан сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг хэрэгжүүлж ирсэн бөгөөд Дээд боловсролын тухай хууль, БСШУ-ы Сайдын тушаал, шийдвэртэй холбогдон гарч буй дүрэм журам, зөвлөмж удирдамжуудыг үндэслэл болгон сургалтын хөтөлбөрт холбогдох өөрчлөлтүүдийг цаг тухайд нь хийж сайжруулан баталгаажуулж байна.

**Үнэлгээ:**

**БҮРЭН ХАНГАСАН**

**Зөвлөмж:**

1. Япон хэлний хичээлийн кредит цагийг нэмэх боломжийг судлах /I-IV дамжаа хүртэл, Япон хэлний хичээлийг хэлний мэргэжлийн багшаар заалгах/
2. Динамик анатоми болон дүрс оношилгоо зэрэг хичээлүүдийн кредит цагийг нэмэх боломжтой эсэхийг хөтөлбөр хэрэгжүүлэгч багийнхан судалж, шийдвэрлэх

## 2.2 Сургалтын аргазүй

Сургалтын аргазүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

### Илрэл нотолгоо:

Хичээлийн хөтөлбөр нь хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, агуулга, ур чадварын хувьд харилцан залгамж холбоотой, суралцах үйл ажиллагаа нь суралцагч төвтэй, тэдний оролцоог дэмжсэн, сургалт нь практик болон онолыг хослуулсан, идэвхтэй арга хэлбэрийг зохистой хослуулсан байна.

1. БШУ-ы сайдын 2014 оны 4 сарын 28-ны өдрийн А/174 тоот тушаалаар батлагдсан “Нийтлэг шаардлага батлах тухай”
2. АШУҮИС-ийн захирлын 2016 оны 1 сарын 22-ны А/04 өдрийн тушаалаар батлагдсан Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам
3. АШУҮИС-ийн “Уламжлалт анагаахын засал” хөтөлбөрийн бакалаврын сургалтын хөтөлбөрүүд
4. АШУҮИС-ийн Төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам А/19 тушаал
5. АШУҮИС-ийн “Төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам” 2021 оны 12 сарын 28-ний өдрийн А/19 тушаал
6. АШУҮИС-ийн видео контентын үнэлгээ. С.Гал-Эрдэнэ, Б.Балжинням, Г.Нарансүх, М.Үзмээ, Х.Сэр-Од, С.Хандмаа, Эрүүл мэндийн шинжлэх ухаан. Эрдмийн чуулган 64 тусгай дугаар, Vkl.18, №2, (66) 2022
7. Одоогийн байдлаар АШУҮИС-д нийт 14 сервер программ ашиглагдаж байна. 2015 оноос сургалтын бүх түвшинд хэрэглэгдэж буй цахим сургалтын систем нь файлын хэмжээ – 1404991, хэрэглэгч – 42660, хичээл – 2906, сорилын шалгалт – 7175, олон хувилбарт сорил – 248677, материал – 29329, видео контент – 23586 тоогоор ашиглагдаж байна.
8. УАУ-ы сургалт хамтран зохион байгуулах хүрээнд 2016-2019 онд Япон улсын Элчин сайдын яам, Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Монгол улсын хүний гавьяат эмч, Анагаах ухааны академийн гишүүн, академич, АУ-ы доктор, профессор Намралын Төмөрбаатар агсны нэрэмжит Хэнтий аймгийн Уламжлалт анагаах ухааны төвтэй хамтарч нийт 5 удаа 490 эмнэлгийн мэргэжилтэн, цэцэрлэг, бага, дунд ангийн 350 хүүхэд хамруулсан эмнэлгийн мэргэжилтэн, олон нийтэд чиглэсэн богино хугацааны сургалтуудыг хийсэн.

9. Токио Ариаке Их Сургуулийн багш оюутнууд 2015 оноос МАУОУС-тай хамтран “Олон улсын оюутны хамтарсан симпозиум”-ыг нийт 3 удаа зохион байгуулж оюутны эрдэм шинжилгээний хурал, эмнэлзүйн дадлага, спортын тэмцээн зэрэг үйл ажиллагааг зохион байгуулсан.
10. АШУҮИС-ийн багш нарын тасралтгүй хөгжих үйл явц, тэдний бүтээлч хамтын ажиллагааг дэмжих, суралцахуй, сурган заах аргазүйн орчин үеийн мэдлэг, чадвар эзэмшүүлэх, технологийн дэвшилд суурилсан цахим сургалтын тасралтгүй хөгжлийг ханган ажиллах зорилготойгоор үйл ажиллагаа явуулан ажиллаж байна.
11. Уламжлалт анагаахын сургалтын хөтөлбөрөөс гадна суралцагчийг судалгаа шинжилгээний ажлын арга барилд сургаж байна. Үүнд:
  - 2021-2022 оны хичээлийн жилийн 3 сарын 25-нд зохион байгуулагдсан “Ирээдүйн үнэ цэнэ-шинэ үеийн судлаачид” сэдэвт АШУҮИС-ийн 80 жилийн ойд зориулсан Монголын уламжлалт анагаах ухааны орчин цагийн дэг сургуулийг үндэслэн байгуулагч Монгол улсын хүний гавьяат эмч, Анагаах ухааны академийн гишүүн, академич, АУ-ы доктор, профессор Намралын Төмөрбаатарын нэрэмжит УАУ-ы салбарын оюутны ЭШ-ний хуралд УАЗ-ийн ангийн 4 дүгээр дамжааны оюутнууд болох С.Лхагвасүрэн нарын “Шагайн үений гэмтлийн дараах үнэлгээ” Б.Сувд нарын “Бүсэлхий нурууны өвдөлтөд жүдо бариа заслын эмчилгээний үр дүн”, Ч.Мөнхсүрэн нарын “УАЗ мэргэжлээр төгсөлтийн дараах ажлын байрны судалгаа”, Л.Батмягмар нарын “Хүзүүний булчингийн чангаралд бариа эмчилгээний үр дүн” гэсэн сэдвүүдээр илтгэл хэлэлцүүлж, С.Лхагвасүрэн, Ч.Мөнхсүрэн нар тусгай байранд шалгарсан.
  - 3 болон 4 дүгээр дамжааны оюутнууд сургалтын төлөвлөгөөний дагуу өөрийн сонирхлоор 2 багц цаг хүртэлх хичээлийг нэмэлтээр сонгон суралцдаг.
  - Хичээлийн жилийн төгсгөлд 3 дугаар дамжааны оюутнууд OSCE шалгалт өгч мэдлэг ур чадварыг үнэлдэг. Энэхүү шалгалтад хичээлийн тооцоогүй оюутнууд ордог ба 70%-иар тэнцэж, тэнцээгүй оюутнууд намар дахин өгөх эрхтэй байдаг.
  - Оюутны сурах үйл ажиллагаа, идэвх, хэлний мэдлэгийг сайжруулах, судалгаа хийх арга барилд сургах зорилгоор оюутнуудын клубүүд байгуулагдан идэвхтэй ажиллаж байна.

#### **Онцлог зүйл:**

1. Хоёр улсын хамтын гэрээний хөтөлбөртэй
2. Ном сурах бичгийн тусгай зөвлөлтэй
3. Сурах орчин нөхцөл, хангамж маш сайн

#### **Дүгнэлт:** /Үнэлгээ өгөх үндэслэл/

Сургалтын аргазүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, суралцагч төвтэй, мэдээлэл харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг, суралцагчид мэдлэг, ур чадвар хандлагыг олгоход чиглэсэн байна.

“УАЗ” мэргэжилтнийг бэлтгэхэд МАУОУС-ийн мэргэжлийн 6 тэнхим, спорт, зөөлөн эдийн гэмтэл, уламжлалт эмчилгээний ур чадварын 2 төв, япон улсын ТАИС-ийн эмнэлэг, 65 ортой МАУТ эмнэлэг, мөн Эрхэс сувилалыг түшиглэн сургалтыг онол болон практикийн түвшинд хослуулан мэргэжилтэн бэлтгэж байна.

## **Үнэлгээ:**

### **БҮРЭН ХАНГАСАН**

#### **1.3. Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

1. БШУ-ы сайдын 2014 оны 4 сарын 28-ны өдрийн А/174 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Дээд боловсролыг бакалаврын мэргэжлийн хөтөлбөрт тавигдах нийтлэг шаарлдага”
2. АШУҮИС-ийн 2021 оны 1 сарын 28-ны өдрийн А/19 тоот тушаалаар батлагдсан тушаалын I хавсралт “Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-д тусгасан үнэлгээний аргачлал
3. АШУҮИС-ийн 2021 оны 1 сарын 28-ны өдрийн А/19 тоот тушаалаар батлагдсан тушаалын II хавсралт, АШУҮИС-ийн сургалтын технологи, чанарын хяналтын журам
4. АШУҮИС-ийн “Уламжлалт анагаахын засал” хөтөлбөрийн бакалаврын сургалтын хөтөлбөрүүд
5. Төгсөлтийн шалгалтын дүнгийн хуудаснууд

#### **Онцлог зүйл:**

1. Үнэлгээний арга барил нь оюутны амжилт, хөгжлийг дэмждэг байх ба нөхцөл байдлын сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэдэг байна.
2. Мөн оюутны гомдол саналыг хүлээж авч шийдвэрлэдэг.
3. Ажлын байрын хүртээмж их, эрэлттэй.
4. Гадны оронд өндөр цалинтай ажиллах боломжтой.

#### **Дүгнэлт: /Үнэлгээ өгөх үндэслэл/**

Оюутны суралцахуйн хүрсэн үр дүнг үнэлэх дүрэм, журамтай, оюутан суралцахуйн зорилтот үр дүнд хүрсэн гэдгийг бодитой тогтоон үнэлэхдээ шударга, ил тод шалгах ба ямар нэг шударга бус зүйлээс урьдчилан сэргийлсэн байна.

Үнэлгээ, шалгалтын болон хичээлийн үйл явцын талаарх суралцагчийн санал, гомдлыг амаар, бичгээр болон хайрцгаар авдаг ба сүүлийн жилүүдийн байдлаар аль ч хэлбэрээр санал гомдол ирээгүй байна.

## **Үнэлгээ:**

### **БҮРЭН ХАНГАСАН**

#### **Зөвлөмж:**

Төгсөгчид болон ажил олгогчидтой хийсэн уулзалтан дээр маш олон удаа давтагдан яригдсан санал: “УАЗ” мэргэжлээр төгсөлтийн дараах мэргэжил дээшлүүлэн суралцах, төрөлжүүлэн, мэргэших сургалтууд дутмаг байна

иймээс энэ талаар хөтөлбөр хэрэгжүүлэгч багийнхан зохих байгууллагад нь уламжлан шийдвэрлэх гарц боломжийг эрэлхийлэх.

### **Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл**

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

#### **3.1 Сургалтын орчин**

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

1. МАУОУС 3,901,82 кв өөрийн эзэмшлийн байр
2. 3,099,545,476 төгрөгний өртөг бүхий номын сан
3. Уламжлалт анагаахын засал мэргэжилтнийг бэлтгэх сургалтын бааз
4. Сургалтын орчныг сайжруулах зорилгоор лекцийн заал, дадлагын өрөөг орчин үеийн тоног төхөөрөмжөөр бүрэн тоногдсон байдал
5. “АШУУИС-д цахим сургалт эрхлэх журам”-ыг АШУУИС-ийн захирлын 2021 оны 01 сарын 28-ны А/19 тоот тушаал

#### **Үнэлгээ:**

#### **БҮРЭН ХАНГАСАН**

#### **Онцлог зүйл:**

Уламжлалт анагаахын засал мэргэжилтнийг бэлтгэх хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай суралцах сургалтын орчин болох сургалтын анги танхим, лаборатори, ур чадварын төвүүд, эмнэлзүйн түшиц бааз эмнэлгүүд, эмнэлзүйн дуураймал орчныг цогцоор бүрдүүлсэн ур чадварын төвүүд болон орчин үеийн сургалтын дэвшилтэт арга болох цахим сургалтын таатай орчныг бүрдүүлсэн байна.

#### **Дүгнэлт:**

Уламжлалт анагаахын засал мэргэжилтнийг бэлтгэх сургалтыг орчин үеийн арга барилаар явуулах боломжийг бүрдүүлж багш оюутны сургалт судалгаа явуулах, өөрийгөө хөгжүүлэх, хэрэгцээтэй мэдээ мэдээллээр хангагдах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх эрүүл аюулгүй орчныг улсын төсвийн болон сургуулийн хөрөнгө оруулалт, Япон улсын хамтын ажиллагааны хүрээнд хангалттай хэмжээнд бүрдүүлсэн байна. Ялангуяа оюутнуудад эмнэлзүйн ур чадвар олгох, бие даан суралцах нөхцөл бололцоог хангах зорилгоор техник, технологийн дэвшил, сургуулийн орчныг шинэчлэн зохион байгуулах талаар тодорхой бүтээлч ажлуудыг хийж хэрэгжүүлжээ. Үүнд:

1. Уламжлалт анагаахын засал мэргэжилтнийг бэлтгэх сургалтын бааз:
  - а. МАУОУС–ийн мэргэжлийн 6 тэнхим, Био-АС-ийн мэргэжлийн 12 тэнхим, НЭМС-ийн 4 тэнхим, АУС-ийн 16 тэнхим, спорт, зөөлөн эдийн гэмтэл, уламжлалт эмчилгээний ур чадварын 2 төв.

- b. 75 ор бүхий хэвтэн эмчлүүлэх МАУТ Эмнэлэг, Эрхэс сувилал нь оюутанд эмнэлзүйн ур чадвар олгох, тэдний дадлага хийх орчныг бүрдүүлсэн байна.
  - c. АШУҮИС-ийн гэрээт Хэнтий, Дорнод, Өмнөговь, Сүхбаатар, Говь-Алтай, Завхан, Дундговь зэрэг аймгуудын нэгдсэн эмнэлгийг түшиглэн эмнэлзүйн сургалтыг сургалтын хөтөлбөрийн цогц чадамжийн дагуу мэдлэг, чадвар, дадлага олгох үйл ажиллагааг 2016 оноос амжилттай хэрэгжүүлж байна.
2. МАУОУС-ийн суралцагсдад зориулан спорт зөөлөн эдийн гэмтлийн үеийн тусламж үйлчилгээ үзүүлэх оношилгоо эмчилгээний ур чадварын төвийг МАУОУС, ТАИС-тай хамтран нээсэн. Ур чадварын төв нь нийт 287 ширхэг материал, багажаар тоноглогдсон байна.
- a. зөөврийн цахилгаан гүйдлийн эмчилгээний аппарат, Super tens нам долгионы эмчилгээний аппарат, Wrinkle Sonic хэт авианы эмчилгээний аппарат, EMS зөөврийн цахилгаан гүйдлийн эмчилгээний аппарат зэрэг 4 төрлийн эмчилгээний аппарат (670 680 000 төгрөг),
  - b. сургалтын DVD (Judo Trerapy Scholaship Training Series),
  - c. 6 төрлийн нурууны хамгаалалт, 13 төрлийн үений хамгаалалт, зөөврийн компьютер 1, проектор 1, бугуй, тохой гэх мэт 5 төрлийн үений үйлдэл хөдөлгөөний модель,
  - d. 8 төрлийн ороох боох материал болон чиг, хүний биеийн араг ясны манекен том, жижиг 2 гэх мэт.
3. 2018 онд 50.088.842 төгрөгөөр 10 нэр төрлийн 10 ширхэг сургалтын компьютер, тоног төхөөрөмж, 2019 онд анги танхим багш ажилчдын хэрэгцээнд зориулж 238.998.617.48 төгрөгөөр 44 нэр төрлийн 850 ширхэг тавилга, эд хогшил, 376.149.003.48 төгрөгөөр 61 нэрийн 300 ширхэг компьютер, тоног төхөөрөмжийг худалдан авч анги танхимыг тохижуулсан байна.
4. Улсын төсвийн болон сургуулийн хөрөнгө оруулалтаар нийт 3.099.545.476 төгрөгийн өртгөөр 2015 оны 9-р сард шинээр 7 давхар төгсөлтийн өмнөх ба төгсөлтийн, төгсөлтийн дараах сургалтанд чиглэсэн номын сантай болсон байна.
5. Цахим зайн сургалтын төвийг АШУҮИС-ийн шинэ номын сангийн 4 давхарт, МАУОУС-ийн 5 давхарт байрлах Эрдмийн өргөөнд тус тус байгуулж цахим орчинд хичээл, дадлага, нэгдсэн шалгалт, ОУ-ын оюутны Эрдэм шинжилгээний хурал, багш эмнэлзүйн судлаач нарын эмчилгээний туршлага солилцох сургалт зэргийг зохион байгуулж байна.

#### **Үнэлгээ:**

#### **БҮРЭН ХАНГАСАН**

#### **Зөвлөмж:**

1. Гадаад хамтын ажиллагааны хүрээнд оюутан солилцоог нэмэгдүүлэн гадаадын их сургуулийн орчинд эмнэлзүйн дадлагажих боломжийг нэмэгдүүлэн, тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах.

### **3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

### **Илрэл нотолгоо:**

1. Программ хангамж симуляци, виртуал, лабораторийн хэрэглээ хүртээмж, тоног төхөөрөмжийг сайжруулсан байдал
2. АШУҮИС-ийн хэмжээнд цахим сургалтын үйл ажиллагаанд хэрэгжиж байгаа Moodle платформд суурилсан Цахим сургалтын <http://elearning.mnums.edu.mn> систем ашиглалт

### **Онцлог зүйл:**

1. Виртуал сургалтын орчин, дуу, дүрс, бичлэгийн студи шинээр байгуулан сургалт хэлэлцүүлэг, хурал семинар явагдаж байна.

### **Дүгнэлт:**

1. Уламжлалт анагаахын засал, уламжлалт эмчилгээ, бариа засал, зүү төөнө засал, иог бясалгалын ур чадварын өрөөг бүрэн тохижуулан сургалтандаа ашиглаж байна.
2. Шинээр сургалтанд Смарт дэлгэц ашиглаж байгаа нь сургалтыг орчин үеийн арга барилаар явуулах боломжийг бүрдүүлсэн, нэг оюутанд ноогдох үзүүлэн, багаж хэрэгслийн тоо хангалттай байна.
3. Сургалтыг цахимаар явуулахад хэрэглэгдэх ажлыг зохион байгуулахад заавар удирдамж зөвлөмжөөр хангаж сургалтын агуулгыг E контент түвшинд боловсруулсан байна. 1-4 курсын 58 хичээлийн 478 контент ашиглагдаж байна
4. Цахим хичээл нэмэгдсэнтэй холбоотойгоор Dell Power Edge R730 сервер буюу 500 gb хатуу дискийн багтаамжтай, 16 gb санах ой хэмжээтэй байсныг Dell Power Edge R730 серверт шилжүүлж, 1 ТВ дискийн багтаамж, 96 gb санах ойн хэмжээг нэмэгдүүлсэн байна.
5. Google Classroom, ZOOM, Серверийн хурд, хүчин чадлыг 4 дахин нэмэгдүүлж Mobicom, Skytel – ийн үүрэн холбооны компаниудад хүсэлт гарган, оюутнууд цахим сургалтын системд дата хямд орох нөхцлөөр хангасан байна.

### **Үнэлгээ:**

### **БҮРЭН ХАНГАСАН**

### **Зөвлөмж:**

1. Дадлагын хичээлийн ур чадвар олгох хэрэглэгдэхүүний хангамж хүрэлцээг нэмэгдүүлэн шинэчлэн сайжруулах, тоног төхөөрөмжийн шинэчлэл, бүрэн бүтэн байдлын урсгал засварыг тогтмол хийж байх.

### **3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

### **Илрэл нотолгоо:**

1. АУТНС нь номын сангийн тухай хуулийн 13.1.1, 13.1.2 зүйл, БСШУЯ-ны сайдын 2020 оны 1-р сарын 29-ний А/43 дугаар тушаал
2. АШУҮИС нь 7 давхар 848 кв талбай, 336 уншигчийн суудал бүхий номын сан
3. Цахим хаягууд: [Library.mnums.edu.mn](http://Library.mnums.edu.mn), багш [tv.xcloud.mn](http://tv.xcloud.mn), оюутан [sw.xcloud.mn](http://sw.xcloud.mn), удирдлага [main.xcloud.mn](http://main.xcloud.mn), [@mnumsedu.mn](mailto:@mnumsedu.mn), [@st.mnums.edu.mn](mailto:@st.mnums.edu.mn)



### **Онцлог зүйл:**

1. АШУҮИС-ийн МАУОУС, АУС-ийн хичээлийн ботаникийн байранд шинээр номын сан байгуулан оюутнуудад уншлагын ном сурах бичгийг нэмэгдүүлэн, уншлагын танхимын ширээ сандлыг MNS 5472:2007 стандартад нийцүүлэн ая тухтай орчин бүрдүүлсэн байна.

### **Дүгнэлт:**

1. АШУҮИС нь 7 давхар 848 мкв талбай, 336 уншигчийн суудал бүхий номын сантай, номын санд бүртгэлтэй багш, ажилтан, оюутнууд [Library.mnum.edu.mn](http://Library.mnum.edu.mn) цахим кодоороо нэвтрэн ном сурах бичгийг уншдаг бөгөөд номын сангийн бүх нэгжүүдэд утасгүй интернэтийн төхөөрөмж суурилуулан бүрэн шинэчилсэн байна.
2. Уламжлалт анагаахын засалын хөтөлбөрт ордог хичээлүүдийн сурах бичиг, гарын авлага, дадлага ажлын номын тоо нийт 2844 төрлийн 20654 ширхэг ном сурах бичиг байна. Үүнээс мэргэжлийн хичээлийн япон, англи, монгол хэл дээрх сурах бичиг, гарын авлага, зураг цомог нь нийт 37 төрлийн 72 ширхэг байна.
3. БСШУЯ-наас хэрэгжүүлсэн “Дээд боловсролын шинэчлэлийн төсөл”-ийн хүрээнд “Ном нөхөн сэлбэх, сэргээн засварлах” төсөл дэмжигдэж, төслийн хүрээнд АШУҮИС-ийн номын сангийн төв байранд ном засварлан сэргээх өрөөг ажиллуулж байна.

### **Үнэлгээ:**

### **БҮРЭН ХАНГАСАН**

### **Зөвлөмж:**

1. Монгол хэл дээрх мэргэжлийн ном сурах бичгийн тоог нэмэгдүүлэх

### **Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

#### **4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

### **Илрэл нотолгоо:**

1. АШУҮИС-ийн МАУОУС-ийн Уламжлалт ангаах засал хөтөлбөрийн тэнхимийн хурлын 2017-2022 оны тэнхимийн хурлын тэмдэглэл
2. Хөтөлбөрийн хорооний байгуулсан тушаал /АШУҮИС-ийн захирлын 2021 оны 10-01ний өдрийн А/204 тушаал/
3. АШУҮИС-ийн УЗ-ийн 2020 онд баталсан “АШУҮИС-ийн хөгжлийн бодлого 2030”

4. АШУҮИС-ийн 33-ийн хурлаар 2020 онд хэлэлцэж дэмжсэн “МАУОУС-ийн стратеги төлөвлөгөө”
5. АШУҮИС-ийн МАУОУС-ийн Уламжлалт анагаах засал хөтөлбөрийн тэнхимийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан
6. АШУҮИС-ийн 2022 оны 10 сарын 27-ны өдрийн А 225 тоот тушаалаар батлагдсан “АШУҮИС-ийн хөтөлбөрийн хорооны журам”
7. Сургалтын удирдлагын болон сургалт зохион байгуулах системүүд
8. Шинжээчдийн хийсэн уулзалт, ярилцлага

### **Онцлог зүйл:**

1. Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагаатай. АШУҮИС-ийн захирлын 2021 оны 10 сарын 1-ний өдрийн А/204 тушаалаар Хөтөлбөрийн ерөнхий хороо болон дэд хороодын гишүүдийг шинэчлэн баталсан.
  - 2017 оноос хойш өнөөдрийг хүртэл тэнхимийн хурлаар 3 удаа,
  - хөтөлбөрийн дэд хороогоор 3 удаа,
  - хөтөлбөрийн ерөнхий хороогоор 1 удаа уг хөтөлбөрийн асуудлыг хэлэлцэн сайжруулалт хийсэн байна.
2. Багш нарын оролцоог хангах зорилгоор багш нар хөтөлбөрийн дэд хорооны нарийн бичгийн даргаар жилийн хугацаатай ээлжлэн ажилладаг.
3. Нэгдсэн зохион байгуулалттай бодлого хэрэгжүүлэх боломжтой. 2016 оны 06 сарын 16-ны өдрийн тушаалаар АШУҮИС-ийн Монгол Анагаах Ухааны Олон Улсын сургууль болон өргөжиж үйл ажиллагаа явуулж байна. Багш бүр ажлын төлөвлөгөө боловсруулан жил тутам гүйцэтгэлээ гарган биелэлт тайлагнаж хэвшсэн.
4. АШУҮИС-ийн стратеги төлөвлөгөөний нэг хэсэг болж үйл ажиллагаандаа дэмжлэг авах боломжтой.
5. Сургалтын удирдлагын болон сургалтын нэгдсэн программ хангамжаар хангагдсан.

### **Анхаарах асуудал:**

1. Хөтөлбөрийн төлөвлөлт, шинэчлэлийн үйл ажиллагаа, хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг тодорхойлоход төгсөгчид, ажил олгогчид болон оюутны санал асуулгын үр дүнг тусгахад анхаарах
2. Сургууль нэгжийн төлөвлөгөөний биелэлтэд дүгнэлт хийн хамт олонд мэдээлдэг байхаас гадна тодорхой байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр төлөвлөх, тайлагнах нэгдсэн загварыг АШУҮИС-ийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөтэй уялдуулах талаар анхаарч ажиллах
3. АШУҮИС-ийн хэмжээнд “UNIMIS программ”-ыг мэдээллийн урсгал, удирдлагын шийдвэр гаргалтын чиглэлээр ашиглах боломжтой байгааг анхаарч сургалтын дүн, оюутны даалгавар бие даалтын түүх харах зэрэг статистик мэдээллээс гадна багшийн ажлын тайлан бэлтгэх, илгээх, нэгтгэх зэрэг мэдээллийн урсгалын хурдыг сайжруулахад ашиглах чиглэлээр санаачлага гарган ажиллах.

### **Дүгнэлт:**

1. Тайланд дурдагдсан зүйл бага хэдий ч байгууллага дээр ажилласан хугацаанд үзэж танилцсан нотлох баримтууд, хөтөлбөрийн тэмдэглэлүүдийг үндэслэн асуудал дэвшүүлэх шийдвэрлэх, төлөвлөх тайлагнах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг боловч түүнийгээ баримтжуулах талаар дутагдалтай байгааг анхаарах шаардлагатай байгааг хөтөлбөрийн баг анхаарах хэрэгтэй.

## **Үнэлгээ:**

## **БҮРЭН ХАНГАСАН**

### **Зөвлөмж:**

1. АШУҮИС-ийн стратеги төлөвлөгөө, хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах нь бүрэлдэхүүн сургуулийн хувьд үүрэг болно. Иймээс хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь төлөвлөлт тайлагналын нэгдсэн загвар боловсруулж тайлангийн үр дүнг нэгтгэн цаашид авах арга хэмжээг тодорхойлдог, түүнийг оролцогч талуудад таниулдаг байх нь зорилго тодорхой байх, оролцогч бүр өөрийн үүргийг ухамсарлах, сургууль удирдлага, хамт олны зүгээс өөрт олгож буй боломжийг ашиглан үр дүнтэй ажиллах, суралцах боломжийг нээнэ гэж үзэж байна.
2. Сургалтын удирдлагын XCloud.mn программ нь хичээлийн хуваарь багш оюутны дүнгийн мэдээлэл нэгтгэх чиглэлээр ашиглагдаад зогсохгүй статистик мэдээллийн сан бүрдүүлэх, богино хугацаанд удирдлагыг мэдээллээр хангах, удирдлагын мэдээлэл боловсруулалтын чиглэлээр ашиглах боломжтой праграмм хангамж байна. Иймд сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулах, багш ажилтнуудын ажлын төлөвлөгөө тайланг иж бүрэн нэг загвараар чанартай нэгтгэн тайлагнахад ашиглах боломжтой байна гэж үзлээ.

### **4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

### **Илрэл нотолгоо:**

1. Хамтын ажиллагааны гэрээ хэлцэл, гэрээ дүгнэсэн актууд
2. Сургуулийн вэб сайт, мэдээлэл

### **Онцлог зүйл:**

1. Багш оюутныг хамтын ажиллагааны хүрээнд урт, богино хугацаагаар сургах, дадлагажуулах боломжтой. 2017 оноос хойш нийт 23 гэрээ шинээр хийгдсэнээс 2022 оны эцсийн байдлаар 19 гэрээ идэвхтэй хэрэгжиж байна.
2. Нийгмийн бүх давхаргад үйлчилгээ үзүүлэх, зөвлөн туслах боломжтой зах зээлд эрэлт хэрэгцээтэй мэргэжлээр сургалт явуулж байгаа.
3. Харьцангуй шинэ хөтөлбөр тул төгсөгчдийн тоо цөөн хэдий ч эргэх холбоог үүсгэх боломжтой салбар гэж үзэж байна.

### **Анхаарах асуудал:**

1. Гэрээ хэлцэл, хамтын ажиллагааны санамж бичгүүдийн хэрэгжилт, гэрээгээр хүлээсэн үүргийн хангалтыг дүгнэх, цаашид анхаарах зүйлсийг тодруулах чиглэлд ажиллах.
2. Оюутны тэтгэлгийг олон чиглэлтэй болгох, боломжийг нэмэгдүүлэх талаар дутагдалтай ажиллаж байгааг онцлож байна. Дотооддоо оюутны тэтгэлгийн төрөл чиглэлийг нэмэгдүүлэх замаар элсэлтийн тоонд нөлөөлөх, хөтөлбөрийн санхүүгийн бие даасан байдлыг хангахад анхаарах.

### **Дүгнэлт:**

Оюутныг дагалдуулан сургах, багш нарыг эмнэлгийн байгууллагад хамтран ажиллах чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил олон, хамтын ажиллагааны гэрээ хэлцэл хийгдэж ажил хэрэг болж байгаа.

### **Үнэлгээ:**

### **БҮРЭН ХАНГАСАН**

### **Зөвлөмж:**

Салбарын эмнэлэг сувилалын байгууллагуудтай хийж буй хамтын ажиллагааны гэрээ нь оюутны дадлагын бааз суурийг өргөжүүлэх чиглэлтэй байгаа нь хөтөлбөрөөр төгсөгчдийн ур чадварыг нэмэгдүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулж байдаг нь дамжиггүй. Иймээс гэрээний үүргийн биелэлт, үр дүнг илэрхийлсэн “Гэрээ дүгнэсэн акт” үйлдэж ажиллах нь хамтын ажиллагааны тогтвортой байдал, цаашдын анхаарах чиглэлийг тодорхойлон ажиллахад тустай гэж үзэж байна.

### **4.3. Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

### **Илрэл нотолгоо:**

1. МАУОУС-ийн төсөв гүйцэтгэл, Уламжлалт анагаах заслын хөтөлбөрийн 2017-2022 оны бакалаврын орлого, тэнхимийн төсвийн хэлэлцүүлгийн тэмдэглэл, төсвийн гүйцэтгэл
2. Шинжээчдийн хийсэн уулзалт ярилцлага

### **Онцлог зүйл:**

1. АШУҮИС нь төвлөрсөн санхүүгийн үйл ажиллагаатай бөгөөд сүүлийн жилүүдэд төсвийн төлөвлөлт, орлого зардал хуваарлалтын бодлогоор төвлөрлийг сааруулах эхний алхмууд хийгдэж байгаа,
2. Нэгдсэн төсөв хийхэд хөтөлбөр хэрэгжүүлэгчдээс санал авдаг соёл тогтсон.
3. Оюутны дадлага хийх материаллаг бааз нь салбарын эмнэлгийн байгууллагуудад түшиглэдэг тул төсвийн бүрэлдэхүүнд багш ажилчдын цалингийн зардлын эзлэх хувь өндөр байдаг.
4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагааны орлого зардлын хувь хэмжээ тайлангийн хугацаанд дараах байдалтай байна. Үүнд:
  - а. Оюутны тоо жил тутам дунджаар 13-25 орчим хувиар өссөнтэй холбоотой сургалтын төлбөрийн орлого жил тутам 15 хувиар өссөн байна. Суурь онтой харьцуулбал оюутны тоо 2.3 дахин, орлого 2.5 дахин өссөн.

- b. Хөтөлбөрийг санхүүжүүлэх зардал жил тутам өсөж байгаа нь багшлах бүрэлдэхүүний болон оюутны тооны өсөлттэй холбон тайлбарлагдаж байна. Тухайлбал цалин хөлсний зардал суурь оноос 3 дахин, хичээл практикийн зардал 3 дахин, сургалтын болон бусад тоног төхөөрөмж худалдан авах зардал 46,5 сая төгрөгөөр нэмэгдсэн бол багш хөгжүүлэх зардал, эрдэм шинжилгээ судалгааны зардлын өсөлт 4-10 дахин өссөн байна.

### **Анхаарах асуудал:**

1. Сургалтын төлбөрөөс бусад хэлбэрээр орох орлогын нэр төрөл хэмжээг нэмэгдүүлэх /сургуулийн орлого 100 хувь сургалтын төлбөрөөс бүрддэг/
2. Сургалтын төлбөрийг зарцуулж буй чиглэлүүдээр зарцуулалтын үр ашгийг тооцоолох, нэг оюутны сургалтын төлбөрийн задаргааг хийн шаардлагатай тохиолдолд нэмэлт санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж ажиллахад анхаарах.

### **Дүгнэлт:**

Хөтөлбөрийн орлогын эх үүсвэр нь зөвхөн сургалтын төлбөр байгаа нь хөтөлбөрийг санхүүгийн хувьд эрсдэлд оруулж байгаагаас гадна хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн санхүүгийн бие даасан байдал алдагдах, сургалтын төлбөрөөр санхүүжүүлж буй зардлыг сургалт эрдэм шинжилгээний чиглэлээр зарцуулах боломжийг хязгаарлаж байна.

### **Үнэлгээ: ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН**

#### **Зөвлөмж:**

1. Хөтөлбөрийн санхүүгийн төлөвлөлтөнд нэгжийн багш удирдлагын оролцоог хангах, гүйцэтгэлийг тайлагнах ажлыг зохион байгуулах боломжийг судлан холбогдох нэгжид уламжлах
2. Хөтөлбөрийн орлогын эх үүсвэрийн нэр төрлийг нэмэгдүүлэх
  - Багш нарын хэрэгжүүлж буй төсөл, эрдэм шинжилгээ судалгааны ажлын орлогыг сургуулийн санхүүгийн тайлангаар тайлагнах нь сургуулийн орлогын нэр төрлийг нэмэгдүүлэхээс гадна хөтөлбөрийн багш судлаачдын эрдэм шинжилгээний ажлыг хэмжих хэмжүүр болох давуу талыг олгох боломжтой.
  - Хамтран ажиллаж байгаа гадаад дотоодын байгууллагуудын хандив тусламжийн орлогыг нэмэгдүүлэх, бүрэлдэхүүн сургуулийн санхүүгийн үзүүлэлтээр тайлагнах талаар холбогдох нэгжид хүсэлт гарган шийдвэрлүүлэх (ӨҮТ 59 тал, хүснэгт 16)
3. Хөтөлбөрт суурилсан төсөв зохиож хэрэгжилтэнд хяналт тавих нь хөтөлбөрөөр суралцагчдын сургалтын төлбөрийн хүрэлцээг тогтоох, хөтөлбөрийн өртөг тооцох боломж бий болгон удирдлын шийдвэрийн оновчтой байдлыг нэмэгдүүлнэ.

#### **Шаардлага:**

Хөтөлбөрийг санхүүгийн хувьд бие даасан байдлыг хангаж ажиллахад анхаарч элсэлтийг хяналтын тоонд хүргэж бүрэн авах, элсэж орсон суралцагчдын тогтоон барихад гадаад дотоодын олон нэр төрлийн сургалтын болон бусад чиглэлийн

тэтгэлэг авах боломжуудыг нээх, мэдээллээр бүрэн хангахад анхаарч ажиллах шаардлагатай.

#### **4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

1. АШУҮС-ийн маркетингийн газрын 2022 оны төлөвлөгөө, гүйцэтгэл
2. Сургууль, тэнхимийн цахим хуудас, танилцуулга
3. Шинжээчдийн хийсэн уулзалт, ярилцлага

**Онцлог зүйл:**

1. Элсэлтийн нэгдсэн болон тусгай бодлого хэрэгжүүлэх, уг үйл ажиллагаанд хөтөлбөр хэрэгжүүлэх тэнхим нэгжээс гадна бүрэлдэхүүн сургууль, нэгдсэн сургууль, салбарын яамны бодлого хэрэгжүүлэх боломжтой.
2. Сургууль хөтөлбөрийн цахим хуудас, XCluod.mn сургалтын удирдлагын мэдээллийн систем, Сургалтын elearning.mn систем, танилцуулгууд, эрдэм шинжилгээний сэтгүүлүүд, оюутны клубуудын үйл ажиллагаа, фэйсбүүк хаягаараа дамжуулан мэдээлэл хүргэдэг.
3. АШУҮИС-ийн нэгдсэн зохион байгуулалтаар хөтөлбөр сурталчлах үйл ажиллагааг хийдэг.

**Анхаарах асуудал:**

1. Хөтөлбөрөөр суралцагчдын тоог нэмэгдүүлэхэд анхаарч санхүүжүүлэх боломжит түвшинд элсэлт авах, идэвхжүүлэлтийн цогц бодлого хэрэгжүүлэх талаар нэгдсэн шийдэлд хүрэх, шаардлагатай бол холбогдох газруудад санал хүргүүлж шийдвэрлүүлэн ажиллах
2. Хөтөлбөрөөр төгсөгчдийн давуу тал, боломжийг сурталчлах талаар анхаарч ажиллах

**Дүгнэлт:** /Үнэлгээ өгөх үндэслэл/

1. Сургууль хөтөлбөрийн цахим хуудас, элсэгчдэд зориулсан танилцуулга зэргээр дамжуулан хөтөлбөрийн оролцогч талуудыг идэвхжүүлэх, хөтөлбөрийн мөн чанар, зорилго зорилтыг таниулах ажлыг хийх шаардлагатай.
2. АШУҮИС-ийн маркетингийн газар жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө гарган гүйцэтгэл тайлагнаж ажилладаг боловч хөтөлбөрийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, шинэ хөтөлбөрүүдийг зах зээлд нэвтрүүлэх, төгсөгчдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, мэргэжилтний ажил үүргийн хуваарьт нөлөөлөх зэрэг нөлөөллийн арга хэмжээг авах талаар хангалттай ажилласан зүйл үгүй байна.

**Үнэлгээ:**

**БҮРЭН ХАНГАСАН**

**Зөвлөмж:**

АШУҮИС-ийн маркетингийн газрын төлөвлөгөөнд нийцүүлэн нэгжийн маркетингийн нэгдсэн төлөвлөгөө боловсруулж хөтөлбөрийн үндсэн зорилгыг таниулахад чиглэсэн нөлөөллийн ажлуудыг хийж гүйцэтгэх, оролцогч талуудын идэвхжүүлэлтийн үйл ажиллагааг төлөвлөж стратеги төлөвлөгөөгөө биелүүлэхэд түлхэц болох алхмуудыг хэрэгжүүлж ажиллах нь алсдаа уг хөтөлбөрийг өргөжүүлэх боломжийг нэмэгдүүлнэ гэж үзэж байна.

## **Шаардлага**

1. Хөтөлбөрийн багшлах бүрэлдэхүүний чадавхыг ашиглан дотооддоо нөлөөллийн бодлого хэрэгжүүлж хөтөлбөрийн байр суурийг бэхжүүлэх, төгсөгчдийн ажлын байрны тодорхойлолтыг ойлгомжтой болгох
2. Оюутны хөгжлийн хөтөлбөрөөр дамжуулан элсэлтийн тоо, сургалтын анги дүүргэлтийг нэмэгдүүлэх ажлыг судалж, хэрэгжүүлэх

### **4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

### **Илрэл нотолгоо:**

1. Сургуулийн вэб хуудас, танилцуулга материал, эрдэм шинжилгээний бүтээл, самбар
2. Сургалтын удирдлагын программ
3. Шинжээчдийн хийсэн уулзалт ярилцлага

### **Онцлог зүйл: /Давуу тал, сайн туршлага г.м/**

1. АШУҮИС-ийн вэб сайтанд нэгдсэн мэдээлэл түгээх, хөтөлбөр хэрэгжүүлэгч бүрэлдэхүүн сургууль нэгжийн зүгээс үйл ажиллагааны цар хүрээг тогтоон мэдээлэл түгээх боломжтой.
2. Сургалтын удирдлагын программ нь оюутан, багш болон сургалт удирдан зохион байгуулж буй нэгжийг сургалтын процессийн мэдээллээр хангаж ажилладаг.
3. Сургуулийн орчинд хэрэглэгддэг цахим хуудсууд:
  - a. Mnums.edu.mn - Сургуулийн вэб хаяг бөгөөд бүрэлдэхүүн сургуулиудын талаарх мэдээллийн авах боломжтой
  - b. Fb: - Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль – 76 мянган дагагчтай

### **Дүгнэлт:**

Оролцогч талуудад ил тод нээлттэй мэдээлэл түгээх боломжит сувгуудыг нэмэгдүүлэх замаар багш ажилтнууд, суралцагчид, төгсөгчдийг хөгжүүлэх, ажил олгогчдыг мэдлэгжүүлэх ажлыг хийх нь хөтөлбөрийн цаашдын хөгжилд тустай бөгөөд нийгэмд хандсан үйл ажиллагааг нээлттэй хэрэгжүүлснээр санхүүгийн олон талт эх үүсвэрийг бүрдүүлэх боломжоор хангах давуу тал болно.

**Үнэлгээ:**

**БҮРЭН ХАНГАСАН**

**Зөвлөмж:**

Сургууль, нэгжийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах, оролцогч талыг сургууль дах үйл ажиллагаа, багш оюутны хөгжлийн өнөөгийн байдалтай танилцуулах ажлыг тасралтгүй хийхэд өөрсдийн зүгээс санаачлагатай ажиллах нь зүйтэй.

**ШАЛГУУР 4:**

**ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ:**

**БҮРЭН ХАНГАСАН**

**Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа**

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

**5.1. Суралцагч сонгох, элсүүлэх**

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

1. Суралцагч сонгох, элсүүлэх журам АШУҮИС-ийн захирлын 2021 оны 3-р сарын 31-ний өдрийн А/68 тоот тушаал
2. Элсэлт 2016 оноос эхлэн АШУҮИС-ийн элсэлтийн бүртгэл нь <http://burtgel.mnums.edu.mn/> цахим бүртгэлийн системээр явагдаж байна.

**Онцлог зүйл:**

МАУОУС нь АШУҮИС болон ТАИС-тай байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд 2016-2017 оны хичээлийн жилээс “Уламжлалт анагаахын засал” мэргэжилтэн бэлтгэх хамтарсан хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

**Зөвлөмж:**

Уламжлалт анагаахын заслын мэргэжлийг шинээр элсэгчдэд эрүүл мэнд, спортын анагаах ухаан, УАУ-ы эрэлт хэрэгцээ ихтэй мэргэжил болохыг сурталчлах, ажил олгогч нарт ажлын байрны тодорхойлолтын дагуу ажиллуулах эрхзүйн орчин бүрдүүлэхэд хөтөлбөр хэрэгжүүлэгчийн багаас санаачлагатай ажиллах.

**Дүгнэлт:**

1. Суралцагч сонгох элсүүлэх журам нь АШУҮИС-ийн захирлын 2021 оны 3-р сарын 31-ний өдрийн А/68 тоот тушаалаар батлагдсан “АШУҮИС-ийн төгсөлтийн өмнөх сургалтанд оюутан элсүүлэх журам”-аар сургалтын хөтөлбөр, элсэлт, нэгдсэн шалгалт авах, жагсаалт гаргах, мэргэжил сонгох, маргааныг шийдвэрлэх ажиллагааг зохицуулж байна.
2. Элсэгчдэд зориулсан мэргэжлийн чиг баримжаа олгох “Удиртгал-07” хоногийн хичээлийг Оюутны хөгжил удирдлагын газартай хамтран сургуулийн танилцуулга, сургалттай холбоотой дүрэм, журам, харилцаа хандлага, ёс зүй,



эрүүл мэнд, мэдээллийн систем-оюутны программ, номын сан танилцуулах зэрэг сургалтыг явуулдаг байна.

3. Одоогоор уламжлалт заслын ангид гадаад оюутан байхгүй байна.

**Үнэлгээ:**

**БҮРЭН ХАНГАСАН**

### **5.2. Зөвлөн туслах үйлчилгээ**

Суралцагчид суралцах, судлах аргагүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрхзүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

1. АШУҮИС-ийн Оюутны хөгжил удирдлагын газар
2. Анги даасан багш нарын тушаал
3. МАУОУС-ийн оюутны байгууллага
4. Ирээдүйн ажил мэргэжлийн талаар өгсөн зөвлөгөө
5. Оюутны хэв журмын сургалт
6. Суралцагчийн судалгаа шинжилгээний үйл ажиллагаа

#### **Онцлог зүйл:**

1. МАУОУС-ийн “Уламжлалт анагаахын засал”-ийн хөтөлбөрийн онцлог нь оюутанд мэргэжил эзэмшүүлэхээс гадна ёс зүй, харилцаа хандлага, соёлтой, урлаг уран сайхан, спортын хийгээд эрүүл мэнд бие бялдарын өв тэгш боловсролтой орчин үеийн нийгмийн чиг хандлагад бүрэн нийцсэн мэргэжилтэн бэлтгэхэд анхаардаг.
2. 2018 оноос цахим сургалтын E.Learning системийг ашиглаж байгаа бөгөөд давуу тал нь орчин үеийн их сургуулийн өнгийг илтгэдэг, сургуулийн сургалтын тогтолцоог нэгдсэн системд оруулан зохион байгуулдаг, оюутны программыг оюутнууд хичээл сонгох, дүнгээ харах, бусад мэдээллийг цаг тухайд нь авахад ашигладаг байна.

#### **Анхаарах асуудал:**

Оюутнуудын судалгааны ажил хийх сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор урамшууллын тогтолцоог бий болгоход анхаарах.

#### **Зөвлөмж:**

1. Судалгааны тэргүүлэх чиглэлээр ажиллаж буй “А” үнэлгээтэй төгсөх боломжтой оюутнуудыг цаашид үргэлжүүлэн суралцах нөхцөл бололцоогоор хангах зорилгоор судалгааны тэтгэлэгт хамруулах.
2. МАУОУС болон тус хөтөлбөрийг хэрэгжүүлэгч мэргэшүүлэх тэнхимийн багш нарын эрдэм шинжилгээний төсөл, судалгааны санхүүжилтээр хийх эрдэм шинжилгээний ажлуудыг өргөжүүлэх.

#### **Дүгнэлт:**

1. Оюутны хөгжил удирдлагын газар /ОХУГ/ нь шинэ элссэн оюутныг бүртгэн авахаас эхлээд төгсөх хуртэлх оюутан суралцагчидтай холбоотой бүхий л үйл ажиллагааг зохион байгуулж, удирдан чиглүүлж ажилладаг. ОХУГазрын бүтэц, үйл ажиллагаанд Оюутны соёлын төв, оюутны эко төв, оюутны өөрөө удирдах сайн дурын байгууллагууд, холбоо, нийгэмлэг, клуб, зөвлөлүүд харьяалагдан ажилладаг бөгөөд Оюутны хөгжил, удирдлагын газар нь их сургуулийн оюутны ёс зүй, харьцаа хандлага, хувь хүний хөгжил, орчин үеийн нийгмийн чиг хандлагад бүрэн нийцсэн үйл ажиллагааг явуулдаг байна.
2. МАУОУС-ийн дамжаа бүрт анги даасан багш нар ажилладаг бөгөөд багш нар оюутнуудын сургалт, хүмүүжлийн үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна. Оюутны сургалт, хөтөлбөр төлөвлөгөө хариуцсан арга зүйчээр Б.Ширчиндоо мөн нэмэлтээр МАУОУС-ийн МАУСТ-ийн дадлагжигч багш Б.Золзаяа нар оюутны үйл ажиллагаа хариуцан ажиллаж байна.
3. Оюутныг хөгжүүлэх чиглэлээр суралцагчдад чиглэсэн үйлчилгээг сайжруулах цогц арга хэмжээ авах, элсэгчдийн сурлагын чанарыг сайжруулах, бүртгэл мэдээллийг төгөлдөржүүлэх, оюутны эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжиж, судлаач оюутны тоог нэмэгдүүлэх, клуб, дугуйлан хичээллүүлэх, хамруулах, урлаг спортын арга хэмжээ зохион байгуулах, оюутныг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах зэрэг ажлуудыг хийгддэг байна.
4. Оюутныг дэмжих, удирдах чиглэлээр хийгдэж байгаа олон талт үйл ажиллагааны хэлбэр:
  - a. төгсөгчид болон суралцагчдын мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх,
  - b. оюутныг эрүүл мэндийн дэмжих үзлэгт хамруулах,
  - c. суралцагчдыг улсын болон олон улсын тэмцээн уралдаан, олимпиадад оролцох боломжийг нэмэгдүүлэх буюу хамтран зохион байгуулах,
  - d. хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэх,
  - e. зээл буцалтгүй тусламж, оюутны тэтгэлэгт хамруулах, хөдөлмөр эрхлэх төвийн үйл ажиллагааг эрчимжүүлэх,
  - f. оюутны байр тэдний тав тух, орчин нөхцлийг сайжруулах
5. 2004 оноос эхлэн (Их Сургуулийн Удирдлага, Мэдээллийн Систем)-ийг сонгон авч сургалтын үйл ажиллагаандаа нэвтрүүлээд 2015 оноос UNIMIS цогц программ хангамжийг шинээр нэвтрүүлсэн байна.

**Үнэлгээ:**

**БҮРЭН ХАНГАСАН**

### **5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо**

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

**Илрэл нотолгоо:**

1. Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлууд АШУҮИС-ийн анхлан санаачилсан “Дусал цус - Дүүрэн амьдрал” нэртэй сайн дураараа цус хандивлах аян
2. Суралцагчийн хөдөлмөр эрхлэлтийг дэмждэг байдал 2016 оны 12-р сарын 07-ны өдрийн “Орлоготой оюутан” үндэсний хөтөлбөр
3. Оюутны ур чадварыг дэмжсэн уралдаан тэмцээн тэмцээн, урамшуулал, санхүүгийн тусламж үзүүлсэн байдал

### **Онцлог зүйл:**

МАУОУС-ийн Оюутны байгууллагаас санаачилсан нийгэмд үзүүлэх үйлчилгээг сургуулийн захиргаа болон зохих шатны байгууллагууд дэмжин хамтран ажилладаг байна.

### **Зөвлөмж:**

Сурлагаар тэргүүлж өсөх ирээдүйтэй оюутнуудыг гадаадын их, дээд сургуулиудад дадлага хийх, туршлага солилцох боломжоор хангах талаар анхаарч ажиллах.

### **Дүгнэлт:**

1. АШУҮИС-ийн анхлан санаачилсан “Дусал цус - Дүүрэн амьдрал” нэртэй сайн дураараа цус хандивлах аянд оролцож нийт 124 багш, оюутан цусаа хандивласан бөгөөд оюутнууддаа талархал гардуулах хурлыг “Олон улсын эрхийг хамгаалах өдөр”-өөр явуулжээ.
2. 2016 оны 12-р сарын 07-ны өдрийн “Орлоготой оюутан” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2018 онд АШУҮИС-ийн төв байранд Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв байгуулагдан Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газартай хамтран үйл ажиллагаа явуулж байна. Цагийн ажил хийх сонирхолтой оюутнууд Оюутны хөгжил удирдлагын газар student@mnumns.edu.mn гэсэн и-мэйл хаягт болон АШУҮИС-ийн оюутны хөгжил удирдлагын газар гэсэн фэйсбүүк пейжээр холбогдож цагийн ажлын талаар мэдээлэл авах боломжтой.
3. МАУОУС, УАУ-ы заслын тэнхимийн харьяа Japanese Judo Therapist Research Club-ээс 2018, 2019 онуудад “Боолтын практик олимпиад” -г 1-3 дамжааны 60 оюутны дунд зохион байгуулж шилжин явах цом гардуулсан байна. 2022 оны 9 сарын 22-нд АШУҮИС-ийн МАУОУС, ТАИС-ийн “Уламжлалт анагаахын засал” хөтөлбөр хэрэгжүүлэгч талууд “ОУ-ын хамтарсан хөтөлбөрийн хөгжил” сэдэвт симпозиум зохион байгуулсан.
4. Оюутанд олгогддог шагнал тэтгэлгийн тоо жил бүр нэмэгдэж байна. Тэтгэлгийн хэмжээ бодитой нэмэгдснээр нийгмийн эмзэг давхаргын оюутнуудын гэр бүлийн санхүүгийн байдалд эерэгээр нөлөөлж сурах нөхцөл боломжийг хангажээ гэж үзэх боломжтой.

### **Үнэлгээ:**

### **БҮРЭН ХАНГАСАН**

#### **5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Шилжилт хөдөлгөөнийг АШУҮИС-ийн захирлын 2021 оны 01-р сарын 28-ны өдрийн А/19 тоот тушаал
- АШУҮИС-ийн захирлын А/142 тоот тушаал

### **Онцлог зүйл:**

Оюутны шилжилт хөдөлгөөнийг бууруулах, чөлөөлөх, суралцах эрхийг түдгэлзүүлэх байдлыг багасгах зорилгоор өвөл, зуны хичээл нөхөлтийг бий болгосон нь шилжилт хөдөлгөөнд орсон давуу тал болжээ.

#### **Анхаарах асуудал:**

“Уламжлалт анагаахын засал”-ын ангиас шилжиж буй оюутнуудын шалтгааныг илрүүлж улмаар шилжилт хөдөлгөөн бууруулах тал дээр анхаарч ажиллах.

#### **Зөвлөмж:**

Дотоод болон гадаадын их дээд сургуулиас шилжин суралцах оюутны хичээлийн зөрүүг хэрхэн тооцох нь тодорхой бус байгааг анхааран эрхзүйн орчин бүрдүүлэх.

#### **Дүгнэлт:**

- Шилжилт хөдөлгөөнийг АШУҮИС-ийн захирлын 2021 оны 01-р сарын 28-ны өдрийн А/19 тоот тушаалаар батлагдсан “Оюутны шилжилт хөдөлгөөн”-ийг зохицуулах журмын дагуу суралцагчийн эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэдэг байна.
- АШУҮИС-ийн захирлын А/142 тоот тушаалд гадаад, дотоодын ижил мэргэжлийн их, дээд, сургуулиас шилжин суралцах оюутны сурлагын голч дүн 2,8 ба түүнээс дээш бол тус сургуульд шилжин суралцаж болно гэж заасан байна.

#### **Үнэлгээ:**

**БҮРЭН ХАНГАСАН**

#### **5.5. Төгсөлтийн баримт бичиг**

- Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

#### **Илрэл нотолгоо:**

Монгол Улсын БСШУС-ын 2017 оны 6-р сарын 5-ны өдрийн А/303 тоот тушаал

#### **Онцлог зүйл:**

ТАИС-тай хамтарсан “Уламжлалт анагаахын засал” хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлдэж байгаа нь АШУҮИС-ийн нэр хүндийг олон улсын түвшинд гаргаж чаджээ.

#### **Дүгнэлт:**

1. Монгол Улсын БСШУС-ын 2017 оны 6-р сарын 5-ны өдрийн А/303 тоот тушаалаар батлагдсан “Боловсролын баримт бичгийн загвар шинэчлэн батлах тухай” тушаалын дагуу Диплом, хавсралт монгол, англи, уйгаржин монгол хэл дээр бичигддэг.
2. БШУ-ы сайдын 2022 оны 5-р сарын 9-ний өдрийн А/160 тоот тушаалаар Уламжлалт анагаахын засал D091704 бакалаврын болон магистрын түвшний мэргэжлийн индекс шинэчлэн батлагдсан.

#### **Үнэлгээ:**

**БҮРЭН ХАНГАСАН**

## Шалгуур

### Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

#### 6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

1. АШУҮИС-ийн багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох журам
2. Багшийн сонгон шалгаруулах журам
3. АШУҮИС-ийн багшийн үйл ажиллагааг зохицуулах журам
4. АШУҮИС-ийн багшийн гүйцэтгэлийг үнэлэх журам
5. УАЗ бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар нь үндсэн багш, гэрээт багш, зочин багш гэсэн багшлах бүрэлдэхүүнтэйгээр ажилладаг
6. 2022 оны байдлаар “УАЗ”-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын эрдмийн зэрэг цолыг тоон байдлаар авахад нийт 94 багш сургалтад оролцдогоос 47% магистр, 53% доктор болон түүнээс дээш зэрэгтэй багш нар. Тодруулбал:
  - Профессор 4, дэд профессор 14, доктор 32, магистр 44.
  - УБЗТэнхимд 2022 оны хичээлийн жилд УАЗ-ийн ангийн хөтөлбөрийг хариуцдаг үндсэн багш – 3, зочин багш – 8 /япон багш/, гэрээт багш – 2 нийт 13 багш ажиллаж байгаагийн 8 /61.5%/ нь доктор, 5 /38.5%/ магистр зэрэгтэй
7. Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхэд БАС, НЭМ, АУС, МАУОУС-ийн нийт 94 багш оролцдогоос 53% нь доктор болон түүнээс дээш эрдмийн зэрэг цолтой.

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

1. Багшийн сонгон шалгаруулалтад удирдах ажилтнуудаас гадна профессорын төлөөлөл оролцуулдаг.
2. Шинээр ажилд орсон багш нарт заавал “Анагаах ухааны боловсрол судлал”-ын 4 багц сургалт явуулдаг.
3. УАЗ-ийн ангийн хөтөлбөрийг хариуцдаг бүх багш нарын 53% нь АУ-ы доктороос дээш зэрэг, цолтой.
4. 2022 – 2023 оны хичээлийн жилд ажиллаж буй УАЗ бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын албан тушаалын зэрэглэлийг 2016 оны хичээлийн жилтэй харьцуулан судлахад профессор, дэд профессор 16.3%-иар, ахлах багш, багш 19.3%-иар тус тус нэмэгдсэн.

**Дүгнэлт:** /Үнэлгээ өгөх үндэслэл/

1. “УАЗ” бэлтгэх хөтөлбөр нь хүний нөөцийн цогц бодлоготой, багш сонгон шалгаруулах журам, багшийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлдэг.
2. Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарын 53% докторын зэрэгтэй ба 16% 15-аас дээш жил ажилласан туршлагатай.

3. Нэг багшид ноогдох оюутны тоо 1:15 тооны зохистой харьцаатай ойролцоо.
4. Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарыг албан тушаалын зэрэглэлийн дагуу хийх ажлын норм хэмжээг тогтоосон ба ЭШ-ний болон ажлын амжилт гаргасан багш нарыг урамшуулан ажилладаг.

## Үнэлгээ:

### БҮРЭН ХАНГАСАН

#### 6.2 Багшийн хөгжил

*Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.*

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- АШУҮИС нь “Багшийн хөгжлийн төв” байгуулан хөгжүүлэх стратеги төлөвлөгөөний хүний нөөцийн чадавхыг дээшлүүлж, нийгмийн баталгааг хангах хөгжлийн хүрээнд чадварлаг боловсон хүчин бүрдүүлэх, багшийн тогтвортой хөгжлийг хангах, багшийн чадамжийг нэмэгдүүлэх, үр бүтээлтэй ажиллах хөшүүргийг бий болгох шаардлагыг үндэслэн “Багш хөгжлийн хөтөлбөр”-ийг боловсруулан ажиллаж байна.

Манлайлах ур чадварыг дээшлүүлэх сургалтууд:

1. “Багшийн судалгааны чадавхыг хөгжүүлэх нь” 2021.11.23, 24, 25
2. “АУ-ы боловсрол судлал 1 2021.11.9-30
3. “АУ-ы боловсрол судлал 2 2021.12.7-28
4. Монгол бичиг – 1 сургалт
5. “Судалгааны аргазүй ба бүтээл хэвлүүлэх нь” 2022.04.29-30
6. “Хувь хүний манлайлал ба стресс менежмент” 2022.5.5, 6

Багшийн хөгжлийг дэмжих аргууд:

1. АШУҮИС-ийн Эрдмийн сургууль 2019 онд гаднын их дээд сургуулиас нийт 4 зочин багшийг шинээр урьж, 3 удаагийн сургалт зохион байгуулж, хамтран ажилласан байна. Үүнд:
  - a. “Чанарын судалгааны аргазүй”
  - b. “Understanding by design, Сурган заах аргазүй”
2. “Анагаах ухааны болон Сувилахуйн судалгааны ёс зүй” сэдэвт сургалтыг нийт багш нарт зохион байгуулж энэхүү сургалтнаас давхардсан тоогоор 165 багш идэвхтэй хамрагдан сертификат гардан авсан байна.
3. Мөн ТАИС-иас тухайн мэргэжлээр нарийн мэргэшсэн АУ-ы доктор, профессор Нобуёши, АУ-ы доктор Итарү Фүкүда, АУ-ы доктор Тоичиро Ямагүчи, АУ-ы доктор Масатака Наказава, ББТ-ны доктор Коижи Кяоми, СШУ-ы доктор Такакүни Сакурай, ЖБЗ-ын доктор Ёшиаки Күбо, ЖБЗ-ын доктор Ясүши Фүкүда нарын нийт 8 япон багш жилд 2 удаа МАУОУС-д ирж танхимаар хичээл заасан.

Багш, судлаачдын урт, богино хугацааны сургалт:

1. Training course on Traditional Chinese medicine for belt and road countries

2. “Seminar on TCM Application and Vaccine Cooperation of Fighting Against Covid -19 for Developing Countries” энэхүү сургалтад 10.14-өөс 11.3-ыг хүртэл хамрагдсан.
3. “Оюуны өмчийн эрхзүй менежментийн үндсэн ойлголт, менежментийг сайжруулах сургалт”-д 2019.03.22-ны өдөр нийт багш нар хамрагдсан.
4. “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй”-д 2019.11.8-ны өдөр нийт багш нар хамрагдсан.
5. ЗТЗТ болон УЗТ хамтран 05.3, 4, 5, 6-ны өдрүүдэд БНХАУ-ын профессор Жан Зө Мин гуайн “Тархины цус харвалтын дараах УАУ болон нөхөн сэргээх эмчилгээ”, “Хүзүү, нурууны өвдөлт, бүсэлхий нурууны язгуур дарагдах хам шинжийн үед хийгдэх хятад уламжлалт анагаах ухааны орчин үеийн чиг хандлага” 4 багц цагийн сургалтыг зохион байгуулсан.
6. БМИҮЗ-ийн зохион байгуулсан МИҮЗШС 2019.03.11
7. 2017.10.9-2018.5.30-ны хооронд АНУ-ын Харвардын АУС-ийн “Training to teachers” сургалтад В.Энхтуяа, Б.Лагшмаа, П.Молор-Эрдэнэ багш нар хамрагдсан.
8. 2018.5.28-2018.6.8-нд Канад улсын Калгарын их Сургуулийн Камминг АУС-иас зохион байгуулсан “АУ-ы боловсрол” сургалтад Ю.Энхтуяа хамрагдсан.
9. “Training Programm for International TCM teaching personnel in Tianjin University of TCM” сургалтад 9.13-19-ний өдөр З.Болортуяа багш оролцсон.
10. 2018.10.28-нд Япон улсын Нагоягийн ИС-ийн профессор Такаши Отани, БАС-ийн Харилцааны ур чадварын тэнхим, АШУҮИС-ийн сувिलाхуйн зөвлөлийн хамтарсан “Хичээлийн судалгааг боловсролын салбарт нэвтрүүлэх нь” сэдвийн төслийн хүрээнд зохион байгуулсан.
11. 2017.11.16-2018.1.19-ний хооронд АШУҮИС-ийн БХТ-өөс зохион байгуулсан “Дотрын өвчний оношзүй хичээлийн сургагч багш” сургалтад тэнхимийн 3 багш хамрагджээ.

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

1. Үндсэн багшийн мэргэжил дээшлүүлэх, эрдмийн зэрэг ахиулахад сургуулийн зүгээс бодитой дэмжлэг үзүүлдэг.
2. Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нар гадаадын 7 оронд 16 удаа урт, богино хугацаагаар мэргэжил дээшлүүлсэн.

**Дүгнэлт:** /Үнэлгээ өгөх үндэслэл/

- АШУҮИС-ийн багшийг хөгжүүлэх үндсэн бодлогын хүрээнд багшийг тасралтгүй хөгжүүлэх бодлого баримтлан жил бүр багш нараас ямар чиглэлээр сургалт авах, өөрийгөө хөгжүүлэх талаар санал асуулга явуулж хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн ажиллаж байна.

**Үнэлгээ:**

**Бүрэн хангасан.**

**6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа**

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

ЭШ-ний хуралд оролцсон байдал:

1. “Эрдмийн чуулган 60” – шилдэг илтгэлээр ахлах багш Ж.Байгальмаа
2. “Эрдмийн чуулган 61”–зочин илтгэгчээр МАУОУС-ийн дотрын тэнхимийн багш С.Доржбат олон багш нар оролцсон.
3. Хөтөлбөр хэрэгжүүлэгч МАУОУС нь ЭШ-ний тэргүүлэх чиглэлдээ нийцүүлэн багш нарын эрдэм судлалын ажлын хүрээнд бий болсон УАУ-ы нийлмэл жор найрлагын судалгааг нотолгоо бүхий туршилт судалгаа хийж оюуны өмч, патент, стандарт боловсруулан баталгаажуулсан байна. Сүүлийн 3-4 жилийн хугацаанд дотоодын болон гадаадын хэвлэлд нийт 164 бүтээл хэвлүүлсэн байна.
4. 2021-2022 оны хичээлийн жилийн 3 сарын 25-нд зохион байгуулагдсан “Ирээдүйн үнэ цэнэ-шинэ үеийн судлаачид” сэдэвт АШУҮИС-ийн 80 жилийн ойд зориулсан Монголын уламжлалт анагаах ухааны орчин цагийн дэг сургуулийг үндэслэн байгуулагч Монгол улсын хүний гавьяат эмч, Анагаах ухааны академийн гишүүн, академич, АУ-ы доктор, профессор Намралын Төмөрбаатарын нэрэмжит УАУ-ы салбарын оюутны ЭШ-ний хуралд УАЗ-ийн ангийн 4 дүгээр дамжааны оюутнууд болох С.Лхагвасүрэн нарын “Шагайн үений гэмтлийн дараах үнэлгээ” Б.Сувд нарын “Бүсэлхий нурууны өвдөлтөд жүдо бариа заслын эмчилгээний үр дүн”, Ч.Мөнхсүрэн нарын “УАЗ мэргэжлээр төгсөлтийн дараах ажлын байрны судалгаа”, Л.Батмягмар нарын “Хүзүүний булчингийн чангаралд бариа эмчилгээний үр дүн” гэсэн сэдвүүдээр илтгэл хэлэлцүүлж, С.Лхагвасүрэн, Ч.Мөнхсүрэн гар тусгай байранд шалгарсан.

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

1. ЭШС-г дэмжих зорилготойгоор холбогдох байгууллагаас санхүүжилт аван томоохон төслүүдийг хэрэгжүүлдэг.
2. “МУАУ-ы 108 боть” төслийг хэрэгжүүлж байгаа.
3. Багшийн ЭШ-ний ажлын гүйцэтгэлтэй холбоотой урамшуулал олгодог.

**Дүгнэлт:**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч МАУОУС нь эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлдээ нийцүүлэн багш нарын эрдэм судлалын ажлын хүрээнд бий болсон УАУ-ы нийлмэл жор найрлагын судалгааг нотолгоо бүхий туршилт судалгаа хийж оюуны өмч, патент, стандарт боловсруулан баталгаажуулсан байна. Цаашид гадаадын хамтарсан төсөлт хөтөлбөрүүдийнхээ тоог нэмэгдүүлэн улмаар эрдэм судлалын ажлын үр дүнгээр бий болсон инновацын бүтээгдэхүүнүүдийг зах зээлийн эргэлтэд оруулахын төлөө хичээнгүйлэн ажиллаж байна.

**Үнэлгээ:**

**Бүрэн хангасан.**

#### **6.4. Багшийн үнэлгээ**

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/



1. АШУУИС-ийн захирлын 2021.5.23-ны өдрийн А/103 тоот тушаалаар “Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэх журам”-ыг шинэчлэн баталсан ба багшийн ажлыг үнэлэх стандартын дагуу багш нар бүр өөрийн үнэлгээний тайлан бичиж, ТӨСБЗГ, Багшийн хөгжил, цахим сургалтын газрын зөвлөлөөр үнэлүүлдэг.
2. Багшийн ажлын үнэлгээ нь нээлттэй бодитой байх зарчмыг баримтлах бөгөөд багшийг хөгжүүлэх тэдний бүтээлч үйл ажиллагааг дэмжих, идэвхжүүлэхэд чиглэгдэнэ.
3. Албан тушаалын зэрэглэлээс хамааран багшийн гүйцэтгэх ачааллыг ялгавартай байдлаар тогтоосон байна.
4. Багш нарын нэг хичээлийн жилд сургалт, ЭШ, мэргэжлийн үйл ажиллагаагаар гүйцэтгэх онооны нийлбэр албан тушаалын зэрэглэл харгалзахгүйгээр 1600 оноо байна.

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

1. Мэргэжлийн багш нараар хангагдсан. АУ-ы боловсрол судлалаар мэргэшсэн, залуу халаагаа бэлтгэх, тэдний эрдмийн ажлыг удирдах чадварлаг баг бүрдсэн.
2. Багшийн ажлын үр дүнг тооцох, үнэлэх, урамшуулах механизм хэрэгждэг.
3. Багшийн хөгжлийн төвтэй, багшийн хөгжилд чиглэж олон төрлийн үйл ажиллагааг төлөвлөж, системтэй зохион байгуулдаг.

**Дүгнэлт:** /Үнэлгээ өгөх үндэслэл/

Багшийн ажлыг үнэлэх стандартын дагуу “УАЗ” бакалаврын хөтөлбөр хэрэгжүүлэгч бүх багш нар өөрийн үнэлгээнээс гадна хөндлөнгийн үнэлгээгээр үнэлүүлдэг бөгөөд ТӨСБЗГ, багш хөгжил, цахим сургалтыг газар болон тэнхим, суралцагч нараар хөндлөнгөөс үнэлүүлэх байдлаар багшийн үнэлгээг хийдэг байна.

**Үнэлгээ:**

**Бүрэн хангасан**

**Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт**

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

**7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт**

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо: /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- АШУУИС-ийн дүрэм. АШУУИС-ийн удирдах зөвлөлийн 2020 оны 09 дүгээр сарын 23- ны өдрийн 002 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт
- АШУУИС-ийн “Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам” 2021 оны 12 сарын 28-ны өдрийн А\19 тушаал

- АШУҮИС—д гадаадын иргэнийг төгсөлтийн өмнөх сургалтад элсүүлэх журам. 2020 оны 01 сарын 30 А/28 тоот захирлын тушаал
- Багшийн алтан дүрэм батлах тухай. 2022 оны 12 сарын 16 А/25 тоот захирлын тушаал
- АШУҮИС-ийн сургалтын технологи, чанарын хяналтын журам. АШУҮИС-ийн Захирлын үүрэг гүйцэтгэгчийн 2021 оны 01 сарын 28-ны өдрийн А/19 тоот тушаал. II хавсралт
- Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам. АШУҮИС-ийн Захирлын үүрэг гүйцэтгэгчийн 2021 оны 01 сарын 28-ны өдрийн А/19 тоот тушаал. I хавсралт
- Төгсөлтийн өмнөх сургалтад оюутан элсүүлэх журам, 2022 оны 04 сарын 19-ний А/19 тоот тушаал
- АШУҮИС-ийн багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох журам - АШУҮИС-ийн захирлын 2021 оны 5 дүгээр сарын 13-ны өдрийн А/103 тоот тушаал

### **Онцлог зүйл: /Давуу тал, сайн туршлага г.м/**

1. АШУҮИС-ийн Сургалтын бодлого зохицуулалтын газар, болон Багшийн хөгжил, цахим сургалтын газраас багшлах боловсон хүчнийг чадавхжуулах боловсрол судлалын болон мэргэжлийн сургалтуудыг тогтмол зохион байгуулдаг байна.

### **Анхаарах асуудал:**

1. АШУҮИС-ийн Захиралын 2021 оны А/179 тоот тушаалаар батлагдсан Хяналт шинжилгээ үнэлгээний газар оролцогчдоос судалгаа авахдаа мэргэжил бүрийн хэрэгцээ сонирхолыг бодитой тогтоохуйц төлөөлөх чадвартай хангалттай тооны төлөөлөл хамрагдаагүй байна.

### **Дүгнэлт:**

1. Хөтөлбөрийн удирдлага оролцогч талуудаас авсан судалгаа мэдээлэл нь төгсөгчдийг 100%, суралцагчдын олонхийг хамруулжээ.
2. Төгсөгчид ба ажил олгогчдын сэтгэл ханамж сайн, төгсөгчид ажлын байраар бүрэн хангагдсан.
3. Суралцагчдаас авсан судалгаанд тус хөтөлбөрөөр суралцагч 64 оюутан хамрагдаснаас:
  - a. ЭЕШ-ын оноогоор тэнцэж спортын эмч болох сонирхлоор элссэн 20
  - b. Уламжлалт засалч мэргэжлийн талаар хангалттай мэдээлэл авч элссэн 60%,
  - c. Төгсөөд мэргэжлээрээ ажиллах хүсэлтэй 53%
2. 2021 оны 10-р сарын 27-нд УАЗ мэргэжлийн сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийсэн:
  - a. Жүдо бариа заслын 13 хичээл 33 багц цаг
  - b. Өрнийн АУ-ы 28 хичээл, 57 багц цаг
  - c. МУА-ын 11 хичээл 26 багц цаг
  - d. Ерөнхий суурь 14 хичээл 24 багц цаг
3. Энэхүү асуумж судалгааны үр дүнд дараах шийдэлд хүрсэн:

- a. Япон хэлний анхан ба анагаахын мэргэжлийн Япон хэлний хичээлийн цагийг нэмж N2 түвшингээс дээш чадвартай болгох шаардлагатай
  - b. Гэмтэл Согог судлалын хичээлийн агуулгыг дахин үнэлэж давхцалыг арилгах
4. Төгсөгчдийн судалгааг үзвэл:
- a. Нийт 52 төгсөгчдийн ажил эрхлэлт 92,3%,
  - b. Мэргэжил дээшлүүлэх сургалтад одоо суралцаж буй 13 буюу 25%
5. 140 багц цагийн 66 хичээлээс Жүдо бариа заслын хичээл 33 багц цаг, бөгөөд үүнээс:
- a. Жүдо бариа заслын түүх
  - b. Жүдо спорт
  - c. Жүдо бариа заслын онол, судалгааны аргазүй
  - d. Боолт хийх аргазүй материал судлал

**Үнэлгээ:**

**БҮРЭН ХАНГАСАН**

**Зөвлөмж:**

1. АШУҮИС-ийн Захирлын 2021 оны А/179 тоот тушаалаар батлагдсан Хяналт шинжилгээ үнэлгээний газар оролцогчдоос судалгаа авахдаа мэргэжил бүрийн хэрэгцээ сонирхлыг бодитой тогтоохуйц төлөөлөх чадвартай тооны хүмүүсийг хамруулж байх.
2. Оролцогчид ба хөтөлбөрийн удирдлага хооронд бодитой эргэх холбоо тогтоож үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх.

**Шаардлага:** /Хэсэгчлэн хангасан, хангаагүй үед заавал бичнэ/

## **7.2. Хөтөлбөрийн үр дүн**

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- АШУҮИС-ийн дүрэм. АШУҮИС-ийн удирдах зөвлөлийн 2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 002 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт. 124
- АШУҮИС-ийн “Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам” 2021 оны 12 сарын 28-ний өдрийн А\19 тушаал
- АШУҮИС—д гадаадын иргэнийг төгсөлтийн өмнөх сургалтад элсүүлэх журам. 2020 оны 01 сарын 30 А/28 тоот захирлын тушаал
- Багшийн алтан дүрэм батлах тухай. 2022 оны 12 сарын 16 А/25 тоот захирлын тушаал
- АШУҮИС-ийн сургалтын технологи, чанарын хяналтын журам. АШУҮИС-ийн Захирлын үүрэг гүйцэтгэгчийн 2021 оны 01 сарын 28-ны өдрийн А/19 тоот тушаал.

- Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам. АШУҮИС-ийн Захирлын үүрэг гүйцэтгэгчийн 2021 оны 01 сарын 28-ны өдрийн А/19 тоот тушаал. I хавсралт
- Төгсөлтийн өмнөх сургалтад оюутан элсүүлэх журам, 2022 оны 04 сарын 19 А/19 тоот тушаал

**Ажил олгогчдоос авсан асуумж судалгаанд 12 аж ахуйн нэгж байгууллага хамрагдаснаас**

- Тус хөтөлбөрөөр төгсөгчдийн мэдлэг, ур чадвар шаардлага хангасан 91%,
- Хандлага сайн 83%,
- Багаар ажиллах ур чадвар 75%,
- Бие даан ажиллах чадвар 66%,
- Харилцааны ур чадвар 66% гарсан байна.

Төгсөгчдийн мэргэжлийн эрх хамгаалах шалгалтын амжилтаас үзвэл 3 удаагийн төгсөлтөөр 46 төгсөгч (6 төгсөгч эрүүл мэндийн ба жирмэсний учир мэргэжлийн эрх хамгаалах шалгалтанд ороогүй) 100% шалгагджээ.

**Онцлог зүйл: /Давуу тал, сайн туршлага г.м/**

1. Үүнээс анхаарал татсан асуудал бол тасралтгүй суралцах орчин бүрдүүлэх талаар тодорхой шийдэлд хүрэх нь чухал гэсэн дүгнэлт гаргаж зохих хэрэгжүүлэлт хийжээ.
2. Ажил олгогчидтой хийсэн ярилцлагын үр дүнд тус хөтөлбөрөөр төгсөгчид ажиллаж байгаа байгууллагадаа мэргэжлээрээ амжилттай ажиллаж байгаа, ажил олгогчдын мэргэжилтний хэрэгцээнд нийцэж байна гэж дүгнэж болох ажээ.
3. Тус хөтөлбөрөөр 3 удаагийн төгсөлтөөр 52 “Уламжлалт Анагаахын Засалч” төгссөн бөгөөд төгсөгчдийн карьер өсөлтийн үр дүнг харуулах зарим баримт:
  - а. Токио Ариаке Их сургуулийн магистрантурыг 3 мэргэжилтэн 2023 онд төгсч ирээд тус тэнхимд багшлахаар бэлтгэгдэж байгаа.
  - б. АШУҮИС-ийн эрдмийн сургуулийн магистрантурт 6 мэргэжилтэн суралцаж байгаа.
4. Тус хөтөлбөрөөр суралцан төгсөгчид Их дээд сургуулиудад багшлах, улсын ба хувийн хэвшлийн УАУ-ы эмнэлэгт –Уламжлалт анагаахын засалчаар, Сэргээн засах төв, сувилалд-засалчаар, биеийн тамир спортын хороо, холбоод болон урлагийн зарим байгууллагад уламжлалт засалчаар ажиллаж байгаа юм байна
5. Тус хөтөлбөрийг хамтран хэргэжүүлэгч талуудын тохиролцсоноор төгсөгчид ирээдүйд Япон улсад мэргэжлээрээ ажиллах боломжтой.

**Анхаарах асуудал:/Сул тал/**

- Цаашид тасралтгүй суралцах, мэргэжилийн зэрэг ахих шатлал тодорхойгүй байгааг ярилцлага дээр төгсөгчид хариуцлагатай илэрхийлж байсан.

**Дүгнэлт: /Үнэлгээ өгөх үндэслэл/**

1. Төгсөгчид ба ажил олгогчдын сэтгэл ханамж сайн, төгсөгчид ажлын байраар бүрэн хангагдсан.

2. Төгсөгчдийн мэргэжлийн эрх хамгаалах шалгалтын амжилтаас үзвэл 3 удаагийн төгсөлтөөр 46 төгсөгч 100% шалгагджээ.

**Үнэлгээ:**

## **БҮРЭН ХАНГАСАН**

**Зөвлөмж:** /Анхаарах асуудалд чиглэсэн байна/

1. “УАЗ” мэргэжлээр төгсөгчид мэргэжлийн зэрэг ахих шатлал, мэргэжлийн шатлал бүрийн ажлын байрны тодорхойлолт оновчтой санал боловсруулж холбогдох төрийн байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

### **7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

1. Энэхүү хөтөлбөр нь шинэ бөгөөд анх удаа Магадлан итгэмжлэлд орж байгаа.
2. Монгол улсын хэмжээнд тус хөтөлбөрөөр суралцсан 3 удаагийн төгсөлтийн мэргэжилтнүүд “Мэргэжлийн эрх” хамгаалан хот, орон нутгийн улс, хувийн хэвшлийн эмнэлэг эрүүл мэндийн байгууллагад амжилттай ажиллаж байна.
3. Төгсөгчид Япон улсад мэргэжлээрээ ажиллах, магистр, докторт суралцах боломжтой.
4. Одоо Токио Ариаке Их сургуулийн магистрантурт Уламжлалт анагаахын засалч хөтөлбөр төгссөн 3 төгсөгч жүдо бариа заслаар суралцаж байна.

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

1. Монгол улсын АШУҮИС, Япон улсын ТАИС-тай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын хөтөлбөр
2. АШУҮИС-ийн Хөгжлийн бодлого 20/30 гэдэг баримтын хэрэгжилтийг 2021 оноос эхлэн үнэлсэн.
3. 2023 оны 01-р сарын байдлаар тус хөтөлбөрийн хэрэгжилтэд давхардсан тоогоор 94 багш оролцож байгаагийн дотор ШУ-ы доктор – 4/9%/, БУ-ы Доктор- 32/35%/, Магистр – 44/47%/, Профессор – 4,2%, Дэд профессор - 17%, Доктор-34%, Магистр 44,8% тус тус ажилладаг.

**Анхаарах асуудал:**/Сул тал/

1. Хөтөлбөрийг олон улсын магадлан итгэмжлэлд оруулах талаар төлөвлөж ажиллах.

**Дүгнэлт:** /Үнэлгээ өгөх үндэслэл/

1. Харьцангуй шинэ хөтөлбөр бөгөөд эдүгээ Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль дүрмийн дагуу ердөөл 3 дахь төгсөлт хиймэгц магадлан итгэмжлэлд амжилттай бэлтгэн анх удаа орж байгаа.
2. Тус хөтөлбөрөөр суралцаж төгсөгчид ажлын байртай, анхны 3 удаагийн төгсөгчдөд ажил олгогчид сэтгэл ханамжтай байгаа.

**Үнэлгээ:**

**БҮРЭН ХАНГАСАН**

**Зөвлөмж:** /Анхаарах асуудалд чиглэсэн байна/

1. Японтой хамтран хэрэгжүүлж байгаа хөтөлбөр учраас Япон улсын боловсролын магадлан итгэмжлэлд орох боломжийг судлаж хэрэгжүүлэх зорилт тавьж ажиллавал төгсөгчид Японд очиж ажиллах баталгаа болохыг үнэлж үзэх.

### ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2			
2	Сургалтын үйл ажиллагаа	2			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2			
4	Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа	2			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	2			
6	Багшийн үйл ажиллагаа	2			
7	Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	2			
<b>ДҮГНЭЛТ</b>		<b>БҮРЭН ХАНГАСАН</b>			

.....  
 .....  
 .....

## НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

ШАЛГУУР		ЗӨВЛӨМЖ
1	<b>ШАЛГУУР 1.</b> Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> <li>• Хөтөлбөрийн оролцогч талуудын санал хүсэлт эрэлт хэрэгцээг тогтмол хугацаанд судлах хамтын үйл ажиллагааг тогтмолжуулж тэдний санал, хүсэлтийг хөтөлбөрийн зорилго, зорилтод хэрхэн тусгаж хөгжүүлэлт хийж байгаа талаар эргэж мэдээлж байх.</li> <li>• УАЗ-ийн оношийн ангилал, эмнэлзүйн удирдамж боловсруулах, хэрэглэх талаар хөтөлбөрийн баг санаачлагатай ажиллах.</li> <li>• Төгсөгчдийн ажиллах байгууллагад зориулсан ажлын байрны тодорхойлолт гаргаж баталгаажуулах, цалингийн сүлжээнд ялгавартай зэрэглэл тогтоолгох боломжийг судалж, зохих шатны байгууллагад уламжлах.</li> </ul>
2	<b>ШАЛГУУР 2.</b> Сургалтын ажиллагаа үйл	<ul style="list-style-type: none"> <li>• Япон хэлний хичээлийн кредит цагийг нэмэх боломжийг судлах /I-IV Япон хэлний хичээлийг хэлний мэргэжлийн багшаар заалгах.</li> <li>• Төгсөгчид болон ажил олгогчидтой хийсэн уулзалтан дээр маш олон удаа давтагдан яригдсан санал: “УАЗ” мэргэжлээр төгсөлтийн дараах мэргэжил дээшлүүлэн суралцах, төрөлжүүлэн, мэргэших сургалтууд дутмаг байна иймээс энэ талаар хөтөлбөр хэрэгжүүлэгч багийнхан зохих байгууллагад нь уламжлан шийдвэрлэх гарц боломжийг эрэлхийлэх.</li> </ul>
3	<b>ШАЛГУУР 3.</b> Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	<ul style="list-style-type: none"> <li>• Дадлагын хичээлийн ур чадвар олгох хэрэглэгдэхүүний хангамж хүрэлцээг нэмэгдүүлэн шинэчлэн сайжруулах, тоног төхөөрөмжийн шинэчлэл, бүрэн бүтэн байдлын урсгал засварыг тогтмол хийж байх.</li> <li>• Монгол хэл дээрх мэргэжлийн ном сурах бичгийн тоог нэмэгдүүлэх</li> </ul>
4	<b>ШАЛГУУР 4.</b> Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>• Салбарын эмнэлэг сувилалын байгууллагуудтай хийж буй хамтын ажиллагааны гэрээ нь оюутны дадлагын бааз суурийг өргөжүүлэх чиглэлтэй байгаа нь хөтөлбөрөөр төгсөгчдийн ур чадварыг нэмэгдүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулж байдаг нь дамжиггүй. Иймээс гэрээний үр дүнг хянаж, тайлагнаж, үүргийн биелэлтийг гаргадаг байх</li> <li>• Хөтөлбөрийн санхүүгийн төлөвлөлтөнд нэгжийн багш удирдлагын оролцоог хангах, гүйцэтгэлийг тайлагнах ажлыг зохион байгуулах боломжийг судлан холбогдох нэгжид уламжлах</li> <li>• Хөтөлбөрийн орлогын эх үүсвэрийн нэр төрлийг нэмэгдүүлэх боломжийг судалж, хэрэгжүүлэх, хөтөлбөрт суурилсан төсөв зохиож</li> </ul>

5	<b>ШАЛГУУР</b> 5. <b>Суралцагчид</b> <b>чиглэсэн</b> үйл <b>ажиллагаа</b>	<ul style="list-style-type: none"> <li>• “Уламжлалт анагаахын засал” хөтөлбөрийг мэргэжлийг шинээр элсэгчдэд эрүүл мэнд, спортын анагаах ухаан, УАУ-ы эрэлт хэрэгцээ ихтэй мэргэжил болохыг сурталчлах, ажил олгогч нарт ажлын байрны тодорхойлолтын дагуу ажиллуулах эрхзүйн орчин бүрдүүлэхэд хөтөлбөр хэрэгжүүлэгчийн багаас санаачлагатай ажиллах.</li> <li>• Дотоод болон гадаадын их дээд сургуулиас шилжин суралцах оюутны хичээлийн зөрүүг хэрхэн тооцох нь тодорхой бус байгааг анхааран эрхзүйн орчин бүрдүүлэх.</li> </ul> <p>Гадаад хамтын ажиллагааны хүрээнд оюутан солилцоог нэмэгдүүлэн гадаадын их сургуулийн орчинд эмнэлзүйн дадлагажих боломжийг нэмэгдүүлэн, тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах.</p>
6	<b>ШАЛГУУР</b> 6. <b>Багшлах</b> <b>бүрэлдэхүүн</b>	<ul style="list-style-type: none"> <li>• МАУОУС болон тус хөтөлбөрийг хэрэгжүүлэгч мэргэшүүлэх тэнхимийн багш нарын эрдэм шинжилгээний төсөл, судалгааны санхүүжилтээр хийх эрдэм шинжилгээний ажлуудыг өргөжүүлэх.</li> </ul>
7	<b>ШАЛГУУР</b> 7. <b>Чанарын</b> <b>үнэлгээ,</b> <b>баталгаажуулалт</b>	<p>АШУҮИС-ийн Захирлын 2021 оны А/179 тоот тушаалаар батлагдсан Хяналт шинжилгээ үнэлгээний газар оролцогчдоос судалгаа авахдаа мэргэжил бүрийн хэрэгцээ сонирхлыг бодитой тогтоохуйц төлөөлөх чадвартай тооны хүмүүсийг хамруулж байх.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Японтой хамтран хэрэгжүүлж байгаа хөтөлбөр учраас Япон улсын боловсролын магадлан итгэмжлэлд орох боломжийг судлаж хэрэгжүүлэх зорилт тавьж ажиллавал төгсөгчид Японд очиж ажиллах баталгаа болохыг үнэлж үзэх.</li> </ul>
	<b>Шаардлага</b> <b>4.3</b> <b>Санхүүжилт</b>	<p>Хөтөлбөрийг санхүүгийн хувьд бие даасан байдлыг хангаж ажиллахад анхаарч элсэлтийг хяналтын тоонд хүргэж бүрэн авах, элсэж орсон суралцагчдын тогтоон барихад гадаад дотоодын олон нэр төрлийн сургалтын болон бусад чиглэлийн тэтгэлэг авах боломжуудыг нээх, мэдээллээр бүрэн хангахад анхаарч ажиллах шаардлагатай.</p>

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг **АШУҮИС-ийн Монголын Уламжлалт Анагаахын Олон Улсын Сургуулийн “Уламжлалт Анагаахын Засал”** хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул **“ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН”** гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг **Эрүүл мэндийн чиглэлээр** хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг : Г.Чойжамц

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг: Б.Наранцэцэг

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг: Л.Наранзаяа

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг: Л.Оюунцэцэг



## V. Уулзалт ярилцлагад оролцогчдын бүртгэл

### Уламжлалт Анагаахын Засалч мэргэжлээр суралцаж буй оюутнууд

Огноо-2023-01-17 /Мягмар/ 13.00-14.00 цагт

№	Овог, нэр	Анги	Курс	Утас	Мэйл хаяг
1	Д.Цолмон	УА3-101	1	85242257	<a href="mailto:GTS22D010@st.mnums.edu.mn">GTS22D010@st.mnums.edu.mn</a>
2	Д.Төгөлдөр	УА3-101	1	88208457	<a href="mailto:GTS22D006@st.mnums.edu.mn">GTS22D006@st.mnums.edu.mn</a>
3	Б.Номин-Эрдэнэ	УА3-102	1	88212936	<a href="mailto:GTS22D015@st.mnums.edu.mn">GTS22D015@st.mnums.edu.mn</a>
4	М.Баярцэцэг	УА3-102	1	95652558	<a href="mailto:GTS22D022@st.mnums.edu.mn">GTS22D022@st.mnums.edu.mn</a>
5	А. Баяржаргал	УА3-201	2	90905509	<a href="mailto:GTS21D002@st.mnums.edu.mn">GTS21D002@st.mnums.edu.mn</a>
6	Б.Анужин	УА3-201	2	94822316	<a href="mailto:GTS21D001@st.mnums.edu.mn">GTS21D001@st.mnums.edu.mn</a>
7	Энххүслэн	УА3-201	2	94206511	<a href="mailto:GTS21D010@st.mnums.edu.mn">GTS21D010@st.mnums.edu.mn</a>
8	М.Намуунзул	УА3-201	2	94760077	<a href="mailto:GTS21D011@st.mnums.edu.mn">GTS21D011@st.mnums.edu.mn</a>
9	Пүрэвсүрэн	УА3-201	2	90149310	<a href="mailto:GTS21D008@st.mnums.edu.mn">GTS21D008@st.mnums.edu.mn</a>
10	Одон	УА3-401	4	91313993	<a href="mailto:GTS18D029@st.mnums.edu.mn">GTS18D029@st.mnums.edu.mn</a>
11	Байгалмаа	УА3-401	4	89986855	<a href="mailto:GTS18D030@st.mnums.edu.mn">GTS18D030@st.mnums.edu.mn</a>
12	Мөнхбаяр	УА3-401	4	91761121	<a href="mailto:P19D014@st.mnums.edu.mn">P19D014@st.mnums.edu.mn</a>
13	Энхжин	УА3-401	4	88752078	<a href="mailto:PMM19D706@st.mnums.edu.mn">PMM19D706@st.mnums.edu.mn</a>
14	Энэрэл	УА3-401	4	95380607	<a href="mailto:GTS18D012@st.mnums.edu.mn">GTS18D012@st.mnums.edu.mn</a>

### УЛАМЖЛАЛТ АНАГААХЫН ЗАСАЛЧААР ТӨГСӨГЧДӨД АЖИЛ ОЛГОГЧИД

Огноо-2023-01-18 /Лхагва/ 11.00-12.00 цагт

№	Овог нэр	Байгууллага албан тушаал	Хэрхэн хамтарч ажилдаг тухай	Утас	Мэйл хаяг
1	Б.Цолмонсүрэн	ҮАЭ захирал	захирал	90003366	<a href="mailto:ceo.iveeltalim@gmail.com">ceo.iveeltalim@gmail.com</a>
2	Ж.Энхчимэг	Монголын Хөл Бөмбөгийн Холбоо	менежер	99099249	<a href="mailto:Chimgee999@gmail.com">Chimgee999@gmail.com</a>
3	Ч.Батнайрамдал	МАУ-ы Төв Эмнэлэг	захирал	99717236	<a href="mailto:batnairamdal@mnums.edu.mn">batnairamdal@mnums.edu.mn</a>
4	С.Сувд	Bomborduk baby care	Захирал	99226724	<a href="mailto:suvd119@gmail.com">suvd119@gmail.com</a>
5	Аянагүл	Тегри мед эмнэлэг	Хүний нөөц	88622684	<a href="mailto:HR@tegrimed.mn">HR@tegrimed.mn</a>
6	Анхзаяа	2-р эмнэлэг УЭТ эрхлэгч	эрхлэгч	90098700	<a href="mailto:Ankzaya.Doc@gmail.com">Ankzaya.Doc@gmail.com</a>
7	Д.Ариунзаяа	Натур мед эмнэлэг	Дотоод хяналт	95212195	<a href="mailto:ariunzaya.dr@gmail.com">ariunzaya.dr@gmail.com</a>
8	Оюундарь	АШУҮИС Төв эмнэлэг	менежер	99061595	<a href="mailto:oyundari@mnums.edu.mn">oyundari@mnums.edu.mn</a>
9	Баярмагнай	Ази мед	Тасгийн эрхлэгч	86002008	<a href="mailto:bayaraanyamaa59@gmail.com">bayaraanyamaa59@gmail.com</a>
10	Мөнхжаргал	1-р эмнэлэг	Тасгийн эрхлэгч	88881625	<a href="mailto:r.munkhjargal@fchm.edu.mn">r.munkhjargal@fchm.edu.mn</a>

### УЛАМЖЛАЛТ АНАГААХЫН ЗАСАЛЧ МЭРГЭЖЛЭЭР СУРАЛЦСАН ТӨГСӨГЧИД

Огноо-2023-01-18 /Лхагва/ 10.00-10.00 цагт

№	Овог нэр	Төгссөн жил	Байгууллага, албан тушаал	Утас	Мэйл хаяг
1	И.Дүүрэнжаргал	2020	Монгол анагаах ухааны төв эмнэлэг-УАЗ	99564147	<a href="mailto:duurenjargal.i@mnums.edu.mn">duurenjargal.i@mnums.edu.mn</a>
2	Л.Буянтунгалаг	2020	Тэгри мед-УАЗ	88680867	<a href="mailto:lbuynaa53@gmail.com">lbuynaa53@gmail.com</a>
3	Б.Нарантуяа	2020	Токио Ариаке их сургууль-магистрант	72705435	<a href="mailto:naraa9804@gmail.com">naraa9804@gmail.com</a>
4	Б.Батдулам	2020	Хөл бөмбөгийн ХанУул багт-УАЗ	88607209	<a href="mailto:gts16d025@st.mnums.edu.mn">gts16d025@st.mnums.edu.mn</a>
5	Е.Алтынжан	2020	Хөл бөмбөгийн Баварианс багт-УАЗ	95181174	<a href="mailto:yerlanjan2211@gmail.com">yerlanjan2211@gmail.com</a>
6	З.Эрдэнэбилэг	2020	Монголын хөл бөмбөгийн холбоо-УАЗ	88783268	<a href="mailto:eegii0bagira@gmail.com">eegii0bagira@gmail.com</a>
7	Д.Энхсүх	2021	Монголын хөл бөмбөгийн холбоо-УАЗ	96645164	<a href="mailto:enkhsukhdugar99@gmail.com">enkhsukhdugar99@gmail.com</a>
8	Э.Будмаа	2021	Натур мед-УАЗ	88763502	<a href="mailto:budmaa33@gmail.com">budmaa33@gmail.com</a>
9	Б.Цэрэнлхам	2021	Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэг	90018828	<a href="mailto:tserenlhamb10@gmail.com">tserenlhamb10@gmail.com</a>
10	Э.Биндэръяа	2021	Хоёрдугаар эмнэлэг-УАЗ	95655897	<a href="mailto:bindery.enkhamgalam2000@gmail.com">bindery.enkhamgalam2000@gmail.com</a>
11	П.Жандагсүрэн	2021	Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэг	98310308	<a href="mailto:jandag0308@gmail.com">jandag0308@gmail.com</a>
12	Б.Сувд	2022	Сос медицина-УАЗ	99443043	<a href="mailto:suwda1217@gmail.com">suwda1217@gmail.com</a>
13	У.Мөнх-Учралт	2022	Тиффани мед-УАЗ	88716220	<a href="mailto:uchkak332@gmail.com">uchkak332@gmail.com</a>
14	Б.Сайнбаяр	2022	Юни мед-УАЗ	88716229	<a href="mailto:bsainbayar117@gmail.com">bsainbayar117@gmail.com</a>
15	Л.Батмягмар	2022	Ази мед-УАЗ	86998860	<a href="mailto:gts18d027@st.mnums.edu.mn">gts18d027@st.mnums.edu.mn</a>
16	Ц.Алтанцэцэг	2022		98977738	<a href="mailto:altantsetseq.ashuvis@gmail.com">altantsetseq.ashuvis@gmail.com</a>
17	С.Лхагвасүрэн	2022	Бомбордук-УАЗ	88800969	<a href="mailto:lhqvsrns@gmail.com">lhqvsrns@gmail.com</a>
18	М.Хулан	ДАУ 2022	3 гал НЭ	80852448	<a href="mailto:munhbaatarhulan82@gmail.com">munhbaatarhulan82@gmail.com</a>
19	Дуламсүрэн	ДАУ 2022	Дархан-АШУҮИС багш	99607816	<a href="mailto:duuyaaduuyaa0019@gmail.com">duuyaaduuyaa0019@gmail.com</a>
20	Н.Ууганцэцэг	ДАУ 2022	Дархан АУТЭ-УАЗ	99267994	<a href="mailto:uuguugnaa9@gmail.com">uuguugnaa9@gmail.com</a>

**ЯРИЛЦЛАГАД ОРОЛЦСОН БАГШ НАР**

№	Овог, нэр	Албан тушаалын зэрэг	Заадаг хичээл	Утас	Мэйл хаяг
<b>БИО АНАГААХЫН СУРГУУЛЬ</b>					
Анатомийн тэнхим					
1	Лхагважаргал	Багш	Анатоми	91015003	<a href="mailto:lkhagvajargal@mnums.edu.mn">lkhagvajargal@mnums.edu.mn</a>
Биеийн тамирын тэнхим					
2	Х.Цэрэнвандан	Ахлах багш	Биеийн тамир	99180059	<a href="mailto:tserenvandan@mnums.edu.mn">tserenvandan@mnums.edu.mn</a>
Биологийн тэнхим					
3	М.Бүрнээ	Ахлах багш	Биологи	99013151	<a href="mailto:burnee@mnums.edu.mn">burnee@mnums.edu.mn</a>
Гадаад хэлний тэнхим					
4	М.Отгонбаяр	Ахлах багш	Англи хэл	95954748	<a href="mailto:otgonbayar.m@mnums.edu.mn">otgonbayar.m@mnums.edu.mn</a>
Харилцааны ур чадварын тэнхим					
5	С.Наранчимэг	Тэнхимийн эрхлэгч	Харилцааны ур чадвар	99279236	<a href="mailto:Naranchimeg@mnums.edu.mn">Naranchimeg@mnums.edu.mn</a>
Эм судлалын тэнхим					
6	С.Сарнай	багш	Эм судлал	80803322	<a href="mailto:sarnai.s@mnums.edu.mn">sarnai.s@mnums.edu.mn</a>
<b>АНАГААХ УХААНЫ СУРГУУЛЬ</b>					
Радиологийн тэнхим					
7	Түвшинжаргал	Тэнхимийн эрхлэгч	дүрс оношлогоо	88889400	<a href="mailto:tuvshinjargal@mnums.edu.mn">tuvshinjargal@mnums.edu.mn</a>
Хүүхдийн анагаахын тэнхим					
8	Б.Амгалан	Ахлах багш	Хүүхдийн өвчин	99026933	<a href="mailto:amgalan@mnums.edu.mn">amgalan@mnums.edu.mn</a>
Мэдрэл судлалын тэнхим					
9	Д.Бямбасүрэн	дэд процессор	Мэдрэл судлал	99011455	<a href="mailto:byambasuren@mnums.edu.mn">byambasuren@mnums.edu.mn</a>
<b>МОНГОЛ АНАГААХ УХААНЫ ОЛОН УЛСЫН СУРГУУЛЬ</b>					
Дотор өвчин судлалын тэнхим					
10	Д.Рэгзэдмаа	багш	МУАУ дотор өвчин судлал	88003050	<a href="mailto:regzedmaa@mnums.edu.mn">regzedmaa@mnums.edu.mn</a>
Зүү төөнө заслын тэнхим					
11	Б.Золзаяа	багш	МУАУ түүх	99071455	<a href="mailto:zolzaya.b@mnums.edu.mn">zolzaya.b@mnums.edu.mn</a>
Монгол анагаах ухаан судлалын тэнхим					
12	Т.Алимаа	багш	МУАУ онол	99171212	<a href="mailto:alimaa.t@mnums.edu.mn">alimaa.t@mnums.edu.mn</a>
Жор судлалын тэнхим					

13	Б.Цэрэнцоо	багш	МУАУ жор судлал	99242596	<a href="mailto:tserentsoo@mnu.ms.edu.mn">tserentsoo@mnu.ms.edu.mn</a>
Уламжлалт эмчилгээний тэнхим					
14	Н.Занди	багш	Иог, МУАУ заслын техник	99188136	<a href="mailto:zandi@mnums.edu.mn">zandi@mnums.edu.mn</a>
Уламжлалт бариа заслын тэнхим					
15	Г.Мөнхзул	багш	Жүдо бариа засал	88186503	<a href="mailto:munkhzul.g@mnu.ms.edu.mn">munkhzul.g@mnu.ms.edu.mn</a>
16	Масатоши Нишикидо	багш	Жүдо бариа засал	88510241	<a href="mailto:masatoshi@mnu.ms.edu.mn">masatoshi@mnu.ms.edu.mn</a>
17	Н.Сарангэрэл	гэрээт багш	Жүдо бариа засал	88333190	<a href="mailto:n.saranagerel@gmail.com">n.saranagerel@gmail.com</a>
18	Р.Чонцолдулам	гэрээт багш	Жүдо бариа засал	80302314	<a href="mailto:chontsol.rl@gmail.com">chontsol.rl@gmail.com</a>

## V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал



АШУУИС

АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ  
ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛЬ  
МОНГОЛ АНАГААХ УХААНЫ  
ОЛОН УЛСЫН СУРГУУЛЬ

12 дугаар хороо, Амгалан, Баянзүрх дүүрэг,  
Улаанбаатар хот, ш/х-48/111, 13270

Утас/Факс: 7700 8666

Цахим шуудан: ismm@mnums.edu.mn

2023.02.17 № 03  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Шинжээчийн багийн  
үнэлгээний тайлангийн тухай

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН  
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ  
ЗӨВЛӨЛД

АШУУИС-ийн Монгол анагаах ухааны олон улсын сургуулийн хэрэгжүүлж буй D091704 индекс бүхий Уламжлалт анагаахын засалчийн бакалаврын хөтөлбөр нь үндэсний хэмжээний хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд орж, шинжээчийн баг 2023 оны 1 сарын 17, 18 өдрүүдэд МАУОУС дээр ажилласан билээ.

Тус хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шинжээчийн багийн үнэлгээний тайлангуудтай танилцаж шинжээчийн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх боломжтой хэмээн хүлээн авсан болно.



ЗАХИРАЛ

*Styong Ayuun*

Д.ЦЭНД-АЮУШ

902060872 ил 5845459

### **ҮІ. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр**

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)  
..... Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн  
дүгнэлт...  
Зөвлөмж....  
Шаардлага...

<b>Магадлан итгэмжлэх эсэх</b>	<b>Магадлан итгэмжлэл олгох хугацаа</b>

### **ҮІІ. Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан  
(огноо).....  
Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн  
дүгнэлт...  
Зөвлөмж....  
Шаардлага...

<b>Магадлан итгэмжлэх эсэх</b>	<b>Магадлан итгэмжлэл олгох хугацаа</b>

